



Эдгар По
Алтан цох

1958



Эдгар По
Алтан цох

1958

Америкийн уран зохиол

ЭДГАР АЛЛАН ПО

АЛТАН ЦОХ

Хоёр дахь удаагийн хэвлэл

Герман хэлнээс Д. Нацагдорж монголчлов.

УЛААНБААТАР 1958

Америкийн уран зохиолч Эдгар Аллан По-гийн «Алтан цох» хэмээх зохиолыг герман хэлнээс анх Монголын шинэ цагийн ууган зохиолч Д. Нацагдорж монголчилжээ. Уг номыг Монгол улсын 25 онд 1000 хувь дармалласан байна.

Одоо манайд нэн ховордсон энэ зохиолыг уншигч олны санал хүсэлтийн дагуу шинэ үсгээр дахин хэвлэв.

Улсын Хэвлэлийн газар

ОРШИЛ

Эдгар Аллан По 1809 оны 1-р сарын 9-нд умарт америк дахь Постон хотод төрөөд нас бартлаа ядуу бэрхтэй амьдарсаар 1849 оны 10-р сарын 7-нд тархины өвчнөөр нас эцэслэжээ.

Эдгар Аллан По хэсүүчлэн явдаг жүжигчин эр эм хоёрын хөвүүн юм. Эцэг эх хоёроо гэнэтийн үхлээр алдаж өнчирсний хойно Ричмондын (Америкийн холбоот улсын нэгэн болох Виргинягийн нийслэл) нэгэн хөрөнгөлөг худалдаачин хүн Аллан гэгчид 1811 оны 12 р сард үрчлэгджээ. Эдгар По 1815 оноос 1820 он хүртэл Невингтонд (Английн нийслэл Лондоны нэгэн хэсэг) сургуульд суралцаад, дараа нь 1826 онд Вирганниягийн (Америкийн холбоот улсын нэг) шинэ нээсэн их сургуульд оржээ. Гэтэл Эдгар По өөрийн дур зоригоор явсан учир тэжээсэн (өргөмөл) эцэгтэйгээ муудалцахад хүрсэн бөгөөд эцэг нь түүнийг энгийн цэрэгт албадан оруулж, 1827 оноос 1830 он хүртэл суулгах цагт түүний биеэ найрамдах байдал олны дунд илэрснээр цэргийн дээд сургуульд дэвшин орж 1831 оны 3-р сарын 6-нд төгссөн нь түүний бие хоёр жилийн гаслант хатуу байдлаас хагацаж авга эгч дээрээ Балтимирт очиж суусан бөгөөд тэнд байсаар 1833 онд Стюард Визитор гэдэг сэтгүүлд нэг бяцхан үгүүлэл ба нэгэн онц гайхамшигтай шүлгийг бичсэн нь үнэхээр

сонгогдон гайхуулж шагнуулжээ. Ингэж түүний залуу насны уран зохиолын авьяас мэргэн нь олонд тодрон эхэлжээ.

Дараа нь Эдгар По Ричмонд, Феладелфия (Хойт америкийн нэгэн их хот) Нью-Йорк (Америкийн холбоот улсын хамгийн их хот) зэрэг хотод зүйл бүрийн сэтгүүлийн эрхлэгч байсан байна. Эдгар По бол тооны ухаанд нэвтэрхий хүн байсан бөгөөд зохиосон зүйл нь гүн бөгөөд нарийн ямагт хүний сэтгэлд оршгүй бэрх зүйлийг бичдэг байжээ. Бичсэн зүйл нь Америк, Европт сонирхогдон дэлгэрч даруй дэлхий дахины яруу найрууллагын эрдэнийн санд үнэлэгдэн гадаадын олон хэлэнд орчуулагджээ.

Энэхүү алтан цох гэдэг зохиолд маш нарийн нууц зүйлийг хүний ухаанаар ухаж болохыг утгачлан зөвхөн өөрийн ухаанаар зохиогоод, мөн өөрийн ухаанаар тайлахын хамт шинжлэх ухааны чанарыг илэрхийлсэн байна. Хүн хэрэв сайн бодвол, ямар ч нууц зүйлийг олж мэдэж болохыг жишээлэн үзүүлжээ. Бас хүний бодол саналын буурал, дэгжил, төөрөл, ололт болон ухааны хир хэмжээгээр сэтгэх санаачлахын зам мөр нь ямар болохыг илэрхийлэн бичсэн байна. Үгүүлэгдэж байгаа зүйл нь дэвшиж буурах цаг үес ба хувилах өөрчлөгдөх арга маяг нь уншигчдын сэтгэлийг нэн ч маажиж хөдөлгөн чадмаар тул одоо цагийн өрнөж бүхий монголын уран зохиолчдод нилээд удиртгал болмоор зүйл мөн. Ялангуяа тус улсын соёл хөгжиж байгаа энэ үед,

дэлхийн алдартай зохиолоос монголчилж олон түмний оюун мэдлэгийг уудам болгон чих нүдийг алс дээгүүр тавиулахыг оролдож байгаа цагт нэгэн зүйлийн сонирхолтой зүйл болох болов уу гэж орчуулсан үүнийг олны өмнө гаргасан бөгөөд ташаа зүйлийг олон эрдэмтэн сэхээтэн оюутнаас уучлан сануулах ажаамуу.

Үүнийг нэгэн удаа уншихад түүний дотор гадаад үг үсгээр тэмдэглэсэн зэрэг нууц зүйл олон орсон ба төвөгтэй утгыг тайлбарласан болох нь хялбараар үл ухагдах зүйл нь юун магад. Гэвч үнэхээр сонирхон уншиж анхаарлыг тавигчдад сайтар эрэгцүүлэн уншсаны хойно амттай зүйл нь илэрхий бөгөөд хүний уйтгарыг хөдөлгөх, сэтгэлийг бишрүүлэх, бахдуулах, инээлгэх зүйл аль аль нь тохиолдох биз ээ.

Орчуулагч

Монгол улсын хорин тавдугаар оны найман сарын наймнаа.

Улаанбаатар хотноо

АЛТАН ЦОХ

Цөм замаа алджээ гэдэг бичигт
айяа айяа энэ хүү солирсон юм уу?
Түүнийг лав тэмээн аалз хазсан биз
гэжээ.

Үгүүлэх нь: Би олон жилийн өмнө Вилльям Легранд гэдэг нэг хүнтэй итгэмжит нөхөр бололцсон билээ. Тэр бол эртний гугенот овгийн угсаатай хүн бөгөөд анхандаа баян байсан боловч зүйл бүрийн гай гамшгийн тохиолоор бүрмөсөн хоосорчээ. Өөрийн зол заяагүйгээс ийм болсондоо ичингүйрч эртэс өвгөсийн үеэс уламжлан оршсон Нью Орлеан (Хойт Америкийн хотын нэр (орчуулагч)) хотыг орхиж өмнө Каролинд (Америкийн холбоот улсын нэг (орчуулагч)) Чарльстон хотын дэргэдэх Сэлливан гэдэг арал дээр шилжин оршсон болно.

Энэ арал бол маш жигтэй. Түүний дээр далайн элснээс өөр юм бараггүй. Урт нь дөрвөн километр хагас орчим, өргөн нь нэгэн мөч явахуйцын хир билээ. Замаг ба зэгсээр үргэлжилж цөлдсөн бөгөөд усны тахианы оршиход тааламжтай, тийм нэгэн үзэгдэхийн төдий өчүүхэн голоор эх газраас тасарчээ. Ургамал нь үнэхээр ховор бөгөөд ядахдаа жижиг нүдэнд үртэхүйц хэмжээний мод ер үл үзэгдэнэ. Энэ арлын баруун өнцөгт Моултрийн боомтын тэнд Чарльстон хотоос зуны лүнхийм халуун ба шороо тоосноос зугадан

зайлж ирэгсдийн орших хэдэн муу сайн модон байшин бүхий газраа ганц хоёрын төдий өргөстэй загзгар дал мод бий. Харин энэхүү баруун өнцөг ба далайн хөвөө дагасан хатуу цагаан элст зурвас газраас гадна, бүх арал дээр Английн цэцэрлэгч нарын онц эрхэмлэн үзэх миртийн (Бутны ургамал 80 орчим янз бий. Их төлөв өмнө америкт ургана. Зарим хэсгийг байшингийн тасалгаа чимэхийн тул тарина. Энэ тухай баруун Европт үлгэр домог олон бий. Зарим газар ургасан нь эмэнд хэрэглэгдэнэ. Латинаар Муг+us гэнэ (орч у у л а г ч)) ширэнгэ үргэлжилсэн аж. Эдгээр бургас мод нь арван таваас хорин тохой орчим өндөр бөгөөд салхины сайхан үнэрийг нэвтрүүлэхгүй хадгалахаар тийм нягт ургажээ.

Тус арлын зүүн өнцөг болох хамгийн мухарт нуугдмал ширэнгийн дотор Легранд нэгэн бяцхан байшин барьж, анх миний санамсаргүй танилцах үеэс эхлэн сууж байсан билээ. Түүнээс хойш би ганцаар аглаг суух хүний байдлыг их л сонирхож, хичээнгүйллийг тавьж харин удалгүй зузаан ханилав. Миний үзэхэд Легранд бол үнэхээр төгөлдөр ухаан цогцолсон бөгөөд сургаал хүмүүжил сайтай болох авч, хүний өшөөнд хорлогдсон ба сэтгэл нь тогтворгүй бас тонгоруу явдалтай болсон ба уйтгар бухимдалд дарагджээ. Түүний цуглуулан хураасан ном бичиг үлэмж боловч хэрэглэдэг нь нэн ховор, хийдэг ажил нь гөрөөчлөх ба загасчлах буюу далайн хөвөөгөөр миртийн дундуур тэнүүчилж, явуу хясаа ба

хорхой шавьж эрнэ. Түүний хорхой шавьж цуглуулах нь даруй Сваммердамаас (Нидерланд улсын хүн, хорхой шавьжийг судалсан эрдэмтэн (1637-1685)) дутуугүй гэж болно. Ийнхүү явахдаа Юпитер гэдэг нэгэн хөгшин негр хүнийг ямагт дагуулан явах бөгөөд, Легранд өөрийн ядуурахын өмнө энэхүү негрт эрх чөлөөг олгож дураар явсугай гэсэн бөгөөд айлгаж шахамдуулсан ч үгүй, аргадаж гуйсан ч үгүй атал тэр маань эзэн Вилльям гээд салахгүй дагаж шудрагыг гүйцэтгэгч болон явна. Бодвол Леграндыг ухаан самуурах янз ороход нь түүний төрлийн хүмүүс хаа хэрхэн явахы нь харгалзуулан сахиулахаар энэ хэдэр негр Юпитерийг зориуд дагуулан тавьсан биз ээ.

Сэлливан арал дээр өвлийн улиралд хүйтэн байх нь нэн ховор, жилийн эргэн тойронд хэрэв гал түлэх учрал тохиолдвол үнэхээр сонин хэрэг. Гэтэл 13-р оны арван сарын дунд үед харин нэгэн тэсгим хүйтэн өдөр байлаа. Энэ өдөр нар шингэхийн өмнөхөн би, ямагт ногоон байгч ширэнгийн дундуур замнан хэдэн долоо хоног учраагүй нөхрийнхөө гэрийн зүг явав. Урьд энэхүү арлаас арван дөрвөн километр зайтай Чарльстон хотноо байх цагт би түүнтэй нааш цааш явалцахад өнөөдрийн адил ийм дөхөм байсангүй билээ. Тэндээс миний бие түүний бяцхан байшингийн дэргэд хүрээд, хуучин заншлаар үүдий нь тогшвол ер хариугүй тул түлхүүрий нь тавьдаг газраас нь олж аваад үүдий нь нээж

орвол тулган дээр нь хурц өнгөтэй цог сүүмэлзэж байх нь сонирхолтой бөгөөд нэн ч тааламжтай үзэгдэнэ. Даруй би гадуур дээлээ тайлж нэгэн сандлыг чучлийн дэргэд татаж авчран суугаад гэрийн эзнийг хатамжин хүлээлээ.

Түүнээс цагаан гэгээ тасармагц, гэрийн хүмүүс ирж дуу алдан, надтай их л баяртайгаар мэндлэлцэн талархана. Юпитер нэгэн чихнээс нөгөө чихэндээ тултал амаа ангайн, шүдээ ярзайлган инээж усны хэдэн тахиагаар үдшийн хоол бэлтгэхийн тул ийш тийш сандран гүйнэ. Легранд сэтгэл нь хөдөлсөн гэмээр буюу юм бодсон мэт байдалтай аж. Тэр урьд үзээгүй хоёр хавтастай хясаа олсноо сонин болгохоос гадна, бас Юпитерийн тусламжаар нэгэн цох барьснаа нэн ч шинэ янзын хосгүй гайхамшигт юм гэж үгүүлэх бөгөөд түүнийг маргааш үзүүлж миний саналыг сонсьё гэнэ. Үүнд би юунд энэ орой үл үзүүлнэ вэ? гэж асууж гараа галын дөл дээгүүр илбэн, ердөө энэхүү хорхой шавьжийн зүйлийг сонирхох байтугай харин үл ойшоон, нохой ид гэж сэтгэж байхад Легранд хэрэв энэ орой чамайг энд байгааг мэдсэн бол гэж халаглаж үгүүлрүүн: Чамтай удтал учирсангүй бөгөөд энэ орой манайд ирээд байна гэж ер санасангүй билээ. Мөнөөхөн намайг харьж ирэхийн замд боомтын Лейтенант Гэ тохиолдсонд би мангуутаж, тэр цохоо түүнд сонирхон үзсүгэй гэж өгсөн тул чамд маргааш өглөөнөөс нааш үзүүлэхийн аргагүй болжээ. Өнөө шөнө манайд хонотугай. Би маргааш

өглөө нар гармагц Юпитерийг тэр цохын хойноос явуулъя. Ер нь тэр бол дэлхий дээр туйлын гайхамшигтай юм гэв. Үүнд би түүний зүг, чи юуг гайхамшигт юм гэнэ гэв? Нар гарахыг гайхамшигт гэж хэлж байна уу? гэвэл, Легранд үгүүлрүүн: Би, нар гарахыг юунд тийнхүү гайхамшигт юм гэх билээ. Тэр цохыг хэлж байна. Тэр бол гялалзсан алтан өнгөтэй, нэгэн хушгын чинээ том, нурууны үзүүрт хоёр хар толбо бий бөгөөд, нэг нь нөгөөгөөсөө уртхан түүний тэмтрүүл нь үнэхээр гайхалтай гэтэл хажуугаас Юпитер дуу алдаж түүнд огт буртаггүй гэж би Вилльям авгайд олонтаа хэлсэн биш үү гээд нэгэн зуур дуугүй болж, бас дахин үгүүлрүүн: Тэр цох бол гадна дотногүй нэвт шувт бүр алтан цох, далавчий нь хэлээд яахав. Би нэгэн насандаа тийм хүнд цох үзээгүй гэхэд Легранд миний үзэхэд их л айхтар янзтайгаар Юпитерийн зүг харж: тийм бол тийм биз. Чи цаад шувуугаа түлэх гэсэн юм уу гээд аман дотроо түүний өнгийг хэмээн үглэн, миний зүг эргэж харан үгүүлрүүн: Тэр цох бол үнэндээ Юпитерийн боддог шиг юмаа. Түүний далавчны гадрын гялтганахтай адил гялалзсан ямар нэгэн төмөрлөгийн хурц өнгийг чи үзсэнгүй биз ээ. Чухам юун болохыг маргааш үзвэл болно. Ганцхүү энэ завсар түүний дүрс хэлбэрийн төдийхнийг үзүүлсүгэй хэмээн босч, нэгэн бяцхан ширээний хажууд бэх үзгийн дэргэд суусан нь цаас эс байв. Легранд нэгэн хайрцагт эрэвч олсонгүй эцэст за яахав энэ хүрэх биз хэмээн өөрийн

ханжаарын өврөөс нэгэн зурвас хиртэй цаасыг гаргаж түүн дээр үзгээр балархай бүдгээр зурна. Миний бие бас ч сайн дулаацаагүй тул энэ үе мөн галын хажууд суусаар байлаа. Гэтэл Легранд өнөөх зургийг дуусгаад суудлаас босолгүй гар сунган надад дөхүүлэн өхийг хүлээн авахын хамт гадна нохой хуцаж хаалгыг маажлахад Юпитер үүдийг нээсэнд Леграндын тэжээсэн ньюфаундленд нохой орж ирээд урьд удаа намайг айлчлан ирж байхад дассан учир над өөд тэмүүлэн харайж хоёр хөлөө миний мөрөн дээр тавин эрхэлнэ. Төдөлгүй түүний хөөрөн баярлаж цовхчих нь намхармагц сайхь цаасан дээр зурсныг ажиглан үзээд өөрийн нөхрийн зурсны үнэн байдлыг гарган хэлэхийг ер эрээлсэнгүй. Нэгэн хэдэн хувь үзэж гайхаад энэ нь үнэхээр жигтэй хорхой аж. Бүр шинэ зүйл гэвэл болно. Түүнтэй адилтгамаар юмыг би ер үзсэнгүй. Ердөө хохимойн толгой шиг юм аа. Түүнээс өөр илүү үүнд адилшаах юу ч үгүй биз гэсэнд Легранд дуу тавин үнэхээр тийм шүү. Хохимойн толгой мэт бий. Нээрэн үхсэн хүний толгойтой адил гэвэл болно. Цаасан дээр мөн ч дамжиггүй тийм үзэгдэх биз. Дээд талын хоёр хар толбо нь нүд шиг бус уу? Дорд нэгэн уртхан толбо нь ам шиг, тэгээд бүхий л хэлбэр нь хохимойн толгой мэт болой гэхэд би: тийм ч тийм ганцхүү чи сайн зурагч бус тул би баахан үл итгэнэ. Биеэр нь үзэж байж мэдье гэтэл, Легран, хэн мэдэх вэ гэж нилээд ундууцсан байдал гаргаж, би

ч ядахдаа тэр зэргийн юмыг зурж дөнгөх учиртай билээ. Сайн багштай байсан бөгөөд тэр намайг тийм мууд тооцдоггүйсэн гэж үг хаяхад би, аа хө би хошигнож хэлсэн билээ. Чиний тэр үнэхээр таатай гавал ажуу. Түүнийг ердийн амьтны

дүрстэй адилгавал туйлын гайхамшигт гавал гэвэл зохино. Хэрэв чиний энэ зурсантай адил болж гэм, чиний тэр хорхой дэлхий дээр хосгүй хорхой болно. Түүгээр сэтгэшгүй хэргийг бэлэгдэлтэй аж. Би бодвол чи өөрийн хорхойгоо хохимойн толгой хорхой гэж нэрлэвэл нийлэмжтэй шиг санагдана. Түмэн бодисын дотор энэ мэтээр адилшаах нэр бас ч олон байх тул тохирох нэгнийг сонгон нэрлэх биз. Гэвч чиний өнөөх хэлдэг тэмтрүүл нь аль вэ гэсэн даруй Легран түүний тэмтрүүлийг асуумуу гэж тачаадсан мэт жигтэй болж бас үгүүлрүүн: Чи түүнийг харахгүй байна гэж үү. Би түүнийг жинхэнэ хорхойд байгаатай яг адил тодорхойгоор зурсан билээ. Түүнээс илүү хэрхэн зурна гэхэд, би за яахав. Би эс үзэвч чи зурсан байж болно гээд түүнийг цааш ундууцуулахыг больсугай гэж бодож, ажиггүй болон, уг цаасыг эгүүлэн өгсөн боловч түүний тэнэгэрхэг байдлыг нэн ч гайхсаар хоцров. Үнэндээ түүний зурсан цоход тэмтрүүл байсангүй бөгөөд ерөнхий байдал нь үнэхээр нэгэн хохимой толгойг модоор сийлсэнтэй адил байсан билээ. Түүнээс Легран мөнхүү цаасыг ихэд тачаадсан байдлаар авч даруйд урж галд хаяхыг завдахад гэнэт мөнхүү зураг руу цочмог

харсан төдий өөр болон ажиглах бөгөөд даруй түүний нүүр улаан болоод удалгүй зэвхий цагаанаар хувирав. Нэгэн хэдэн хувь уул зургийг суусан газраа нарийвчлан үзээд, эцэст босож, нэгэн лаа аван ирээд байшингийн булан дахь авдрын дээр сандайлан сууж сайхь цаасыг эргүүлж тойруулан, нарийвчлан үзэж бас дахин шалгана. Нэг ч үг үгүүлэхгүй бөгөөд түүний зан байдал нь их л жигтэй. Үүнд би түүний тэнэгэрхэг аашийг цааш хөдөлгөсний хэрэггүй гэж бодож, мөн дуугүй суув. Гэтэл тэр өврөөсөө нэгэн гэтэвчийг гаргаж цаасыг түүний дотор хямгатайгаар агуулаад, бичгийг ширээний шургуулганд хийж цоожилно. Түүний мөнөөхөн догдолсон байдал нь дарагдавч дув дуугүй суун улам жигтэй болох бөгөөд орой болоход нэн ч үүргэлсэн мэт юм бодон суух нь би түүний учрыг олж ядлаа. Миний бие анх ирэхдээ урьд адилаар тэднийд хоносугай гэж зорьж ирсэн боловч гэрийн эзэн ийм байдалтай байх тул явбал дээр гэж бодож босов. Тэр өнжсүгэй гэж хэлэх ч үгүй ба төдий л хайхрамжгүй суух бөгөөд харин намайг гарч одоход урьдаас улам элэгсэг янзтай гар барилаа.

Түүнээс хойш дөрвөн долоо хоног өнгөрсний хойно Леграндын зарц Юпитер Чарльстон хотноо манайд айлчлан ирэв. Энэ завсар би Леграндтай уулзсангүй ба түүний тухай юу ч сонссонгүй билээ. Гэтэл үзвэл, тэрхүү номхон хөгшин негр энэ өдөр их л уйтгартай байдалтай явах учир би даруй

цочиж миний нөхөр ямар нэгэн гамшигт тохиолдов уу гэж хирт хийж, за Юпи аа юу байна. Танай эзэн сайн уу гэж асуувал, негр үгүүлрүүн: Эрхэм ээ манайх цугаараа сайн ч сайн гэвч тийм сайн бус гэв: Үүнд би гайхаж, юу болов. Тэр өвдөв үү? Яасан тоогүй юм бэ, хэрхсэн бэ гэж лавлавал Юпитер үгүүлрүүн: Юу гэх вэ, тэр юунаас болсныг мэдэхгүй. Гэтэл хүнд өвчинтэй байна гэхэд би, Юпитер аа, тэр үнэхээр хүндээр өвдсөн гэж үү? Тэгсэн юм бол чи тэр даруйд юунд надад эс хэлэв. Тэр хэвтэж байна уу гэж асуувал, Юпитер үгүүлрүүн: тэр хэвтсэн бус, тэгэвч нэг юм болжээ. Хөөрхий муу эзнийхээ тул би их зовж байна гэв. Үүнд би Юпитерээс асууруун: Чи ер нь юу хэлж байна. Танай эзэн өвчинтэй гэнэ. Хэрэв тийм болбол чухам хэрхэн өвдсөнөө чамд үл хэлэв үү гэвэл, Юпитер үгүүлрүүн: Эрхэм авгай та ийнхүү сүйд болох хэрэггүй. Тэр юу ч үл хэлнэ. Ямагт толгойгоо унжуулж, мөрөө хавчин гэрээс гарч тэнүүчлэх ба царай нь зэвхий болсон бөгөөд өдөр бүр юм зурна гэнэ. Тэгээд юу хийж байна гэвэл, Юпитер үгүүлрүүн: Тэр самбар дээр олон тоо зурах бөгөөд, би ер тийм жигтэй тоо үзээгүй билээ тэр түүнд ухаан алдан улайж ямагт нүднээс үл салгана. Сүүлчийн хэдэн өглөө нарнаас өмнө намайг дагуулан гэрээс гарч үүгээр түүгээр дэмий тэнэхэд нь би түүнийг залхаахаар нэгэн цавчирга бэлтгэсэн боловч, гэдрэг буцаж ирсний хойно үзвэл түүний царай нь тун муу байхад, би бас өрөвдөөд орхив гэлээ. Үүнд

би ихэд цочин гайхаж хэлрүүн: Яаж байгаа чинь тэр вэ? Чи тэр муу амьтанд тийм хатуу байж болохгүй. Тэр чиний гарыг даахгүй биш үү? Бүү занчигтун. Харин чи түүний өвдсөн буюу өөр байдалтай болсон нь ер юунаас болсныг ажиглаж мэдсэнгүй юу? Хэдийн намайг байхад ямар нэгэн аягүй зүйл болоогүй биз гэвэл Юпитер үгүүлрүүн: Аа эрхэм ээ! түүнээс аягүй зүйл юу ч болоогүй. Ганцхүү таны очсоноос өмнө ч биш, хойно ч биш чухам тэр өдрөөс эхэлсэн билээ гэхэд чи юуг хэлнэм гэж асуувал, Юпитер үгүүлрүүн: Авгай, би цохыг хэлж байна. Хамаг учир түүнээс үүссэн юм гэв. Би бас цааш нь лавлавал түүний хэлэх нь: Тэр бол ёстой алтан цох, манай эзний толгойг магад тэр хазав гэв. Үүнд чи хэрхэн учир тийнхүү бодов гэж асуувал, Юпитер үгүүлрүүн: Юу гэвэл тэр цох айхтар сүрхий савартай амтай амьтан, би ер тийм гамшгийн цохыг үзсэнгүй билээ. Тэр аль ойр тохиолдсон юм бүхнийг хазах буюу савардана. Вилльям авгай түүнийг анх чангаар атгасан боловч даруйд нь газар алдсан билээ. Би бодвол тэр зуур цох Вилльям авгайг хазсан биз. Би тэр дор нь тэр цохыг жигшсэн бөгөөд хуруугаа хүргэж ч үл чадна. Анх авчрахдаа тэндээс нэг хэсэг цаас олж жийрэглэн хөлөөс нь чимхэнэ гэхэд би асууруун: Тэгээд чи тэр цох танай эзнийг магад хазсан болоод түүний хазсанаас болоод танай эзэн өвчин олсон гэж бодож байна уу гэвэл, Юпитер би шууд тэгж бодохгүй ердөө хэрэв түүнийг алтан цох хазсангүй бол тэр

юунд ямагт алт гэж зүүдлэх аж. Тэр урьд алтан цохын тухай сонссоноо ярьж байхы нь сонссон билээ гэв. Үүнд тэр алт гэж зүүдэлдгийг чи хэрхэн мэдэв гэвэл, Юпитер хариулруун: Түүнийг яаж мэдэв гэвэл, тэр зүүдэндээ алт, алт гэж үглэнэ гэхэд би тэгээд чиний хэлдэг зөв байж болно. Гэвч та өнөөдөр ямар золоор гийгүүлэн ирэв гэвэл, тэр та юу хэлж байна гэж учрыг ухахгүй тул Легранд авгай чамаар ямар нэгэн захиа өгөв үү? гэж асуухад, Юпитер юу ч өгөөгүй. Ердөө энэхэн гэж өврөөс нэгэн захиа гаргаж өгснийг задалж уишвал түүний үг нь:

Амраг нөхрөө! Чамтай нүүр учирсангүй өдий удсан минь юунаас болов. Надад ямар нэгэн зүйлд юм санасангүй болов уу гэж итгэнэ. Бодвол хэрхэвч тийм биш биз ээ. Чамайг манайд ирсэн өдрөөс хойш, миний сэтгэл их л хөдлөн хөөрнө. Би чамд хэлэх нэг зүйл бий. Гэвч чамд хэрхэн хэлбэл зохих ба ердөө чамд хэлбэл зохих эсэхийг олж үл мэднэ. Миний бие базаахгүй болсоор нилээд удлаа. Хөгшин нөгр сайн сэтгэлээр надад хичээнгүйллийг гаргахдаа намайг бараг тэсэшгүйгээр зовооно. Би түүнд хэлэлгүйгээр гэрээс гарч эх газрын аараг ухаагаар ганцаараа хэдэн өдөр явсан учир, тэр намайг залхаахаар нэгэн бүдүүн цавчирга бэлтсэн, үүнийг хэн ч үл итгэх биз.

Завшаанд миний царай зүс дорой байснаар тэр өрөөдөж цавчиргадахыг хэлтрүүлсэн болов уу? Чамайг тэр ирснээс хойш би хорхой шавьж цуглуулах ажлаа цааш явуулж чадаагүй ээ. Хэрэв чи чадвал Юпитерийн хамт ирнэ үү? Бн чамтай энэ үдэш нэгэн чухал хэрэг хэлэлцэхийг хүсэх тул эрхбиш хичээж ирнэ үү? Энэ хэрэг бол туйлын чухал болохыг чамд илтгэсүгэй.

Үүрд чиний Вилльям Легранд гэжээ.

Энэ захиаг үзвэл сэжиглэлтэй зүйл олон, захианы доторхи үг нь Леграндын ерийн бичдэг захианаас их л өөр тэр ямагт юуныг зүүдлэх ба ямар нэгэн шинэ царцаахай, түүний уульхай тархинд оршсоныг хэрхэн мэднэ. Түүнд ямар туйлын чухал хэрэг байх аж. Гэтэл түүний тухай Юпитерийн хэлсэн үгийн дотор сайн нь ер үгүй. Үүнд би анхандаа өөрийн нөхөртөө ямар нэгэн цаг бусын аюул тохиолдов уу? гэж айн гайхсаар байсан бөгөөд, эцэст мөн ч түүний ухаан нь самуурсан байж болзошгүй гэж бодлоо. Түүнээс миний бие гайхан саадахыг шууд орхиж даруй бэлтгэн негрийг дагалдан одлоо. Хотоос гарч онгоц татах газар хүрвэл, бидний сууж явах завийн дотор нэгэн хадуур гурван хүрз тавьсан байна. Эдгээр нь юун юм бэ? гэж асуувал Юпитер юу байх вэ? гурван хүрз нэг хадуур биш үү гэж хариулав. Үүнд би тийм ч

тийм байна. Ганцхүү эдгээрээр юу хийнэ гэвэл, Юпитер үгүүлрүүн: Эдгээрийг Вилльям авгай хотоос худалдан авахуулсан билээ. Учиргүй үнэтэй бөгөөд өдий төдий хайран мөнгөө сүйтгэв гэхэд би, танай эзэн энэ мэтийн учир зүггүй юмаар ер нь яах гэж байгаа юм бэ гэвэл Юпитер үгүүлрүүн: Тэр түүгээр юу хийхийг хэн мэднэ. Бодвол цөм тэр цохын учир болохоос зайлахгүй биз гэв. Үүнээс би хичнээн асуувч ямагт цох гэхээс өөр сэтгэлийг тогтоох үг Юпитерээс гарахгүй тул онгоцонд сууж дарвуулыг шурагдан одлоо. Салхины ая явах замыг дагалдсан сайхан өдөр байсан тул удалгүй Моултри боомтын умарт этгээдийн бяцхан буланд онгоцыг татан бууж тэндээс гурван километр орчим явганаар яваад үд нилээд өнгөрсөн хойно Леграндын гэрт хүрвэл Легранд манийг онц адган хүлээсэн аж. Учирмагц Легранд миний гарыг их л хийрхүү байдалтайгаар барихад би нэн зэвүүцэж сэжиглэн бодож байсан зүйл улам өрнөлөө. Царай нь зэвхийрэн хувхайрсан бөгөөд ёнхор хоёр нүд нь ерийн бишээр гялалзан гялтганана. Би түүнтэй мэндэлсний хойно хэлэх үгийг олж ядахдаа лейтнант Гээ-гээс цох хорхойгоо эргүүлэн авчирсан уу гэвэл, Леграндын нүүр ихэд улаан болж үгүүлрүүн: Бн түүний маргааш өглөө нь эргүүлэн авчирсан билээ. Дэлхий дээр би тэрхүү цохоос яахин хагацна. Юпитерийн бодсон нь үнэхээр зөв аж гэв. Үүнд миний сэтгэлд улам сэжиг төрж юун болох учрыг лавлавал тэр царайг маш

төв болгож, мөнхүү цох бол ёстой алтан цох ажуу гэхэд, би түүнийг лав солиорчээ гэдгийг ажин авлаа. Гэтэл Легранд энэхүү цох бол миний зол заяаг нээнэ гэж баяртайгаар инээмсэглэж энэ миний гэр хөрөнгийг гэдрэг сэргээн байгуулна. Тиймийн тул үүнийг би ихэд эрхэмлэн үзэх минь гайхалтай хэрэг биш билээ. Нэгэнт хувь зохиолоор надад ирсний тул би ганцхүү түүнийг зохистойгоор хэрэглэн чадаж түүний заасан алтыг олж авах хэрэгтэй болно гээд Юпитерээ тэр цохыг аваад ир гэхэд Юпитер цочсон мэт болж, би түүнд гар хүрэхийг ч хиртхийх тул та өөрөө авчирвал дээр гэсэнд Легранд өөрөө их л төв бөгөөд баясгалантай царай гарган босож, цохыг нэгэн шилэн хайрцаг дотроос гарган үзүүлэв. Тэрхүү цох бол үнэхээр гайхамшигтай цох бөгөөд түмэн бодисыг судлагчид олж үзээгүй зүйл болох нь шинжлэх ухааны талаар олзын дээд гэж болно. Нурууны нэгэн шувтарганд хоёр дүтрэг хар толботой ба нөгөөд нэгэн уртлаг толботой, далавчийн гадар нь туйлын хатуу болоод гялалзах нь арчмал алттай яг адил үзэгдэнэ. Тэр цохын хүнд нь үнэхээр гайхалтай бөгөөд бодвол Юпитерийн алт гэж санах нь зөв ажуу. Харин Легранд юун учраас тийнхүү төөрснийг олж үл мэдэв.

Би цохыг үзэж дуусмагц Легранд их л чухал хэрэгтэй мэтээр би чамайг дуудуулсны учир нь чамтай зөвлөж энэхүү цох ба зол заяаг хэрхэн ашиглахад туслуулъя гэсэн билээ

гэхэд, би түүний үгийг мохоож эрхэм нөхөр чи эрүүлгүй биз сэргийлэн болгоомжилж аргалуулах хэрэгтэй. Чи хэвтэгтүн. Би чамайг эдгэртэл хэд хоног байсугай. Магад хомх өвчин туссан биз. Судсаа үзүүлнэ үү гэж судсыг үзвэл, үнэндээ хомходсон тэмдэггүй ажуу. Үүнд би Леграндын зүг чи хомходсон биш ч атугай өвдөж болно. Би чамайг эмнэсүгэй. Юуны урьд орондоо хэвтэгтүн дараагаар... гэж цааш залгамжлан үгүүлэх гэтэл Легранд чи солиорч байна гэж миний үгийг тасалж үгүүлрүүн: Хэдийгээр миний сэтгэл хөдлөн хүлцэн ядаж байгаа боловч бие минь эрүүл энх байна. Хэрэв намайг үнэхээр хайрлавал энэхүү сэтгэлийн хөдөлгөөнийг дарж өгнө үү гэхэд, би түүнийг хэрхэн дарж чадах вэ гэвэл, Легранд үгүүлрүүн: Маш хялбар, эдүүгээ Юпитер бид хоёр эх газрын уулнаа заншлан одно. Ийнхүү явахад бидэнд туслах итгэмжтэй нэгэн хүн хэрэгтэй. Үүнд миний хэрэглэж болох ганц хүн чи билээ. Хэрэг бүтэвч эс бүтэвч чиний мэдсээр бүхий миний сэтгэлийн хөдөлгөөн үүгээр арилна гэхэд, би ямар тухай хэрэг боловч дуртай гүйцэтгэнэ. Гагцхүү лавлах нь, энэхүү чөтгөрийн цох тэр хүү ууланд одох явдалд холбогдол байна уу гэвэл, Легранд байлгүй яахав гэхэд, тэгвэл би ийм завхарсан явдалд явалцахгүй гэхэд, Легранд, хэрэв чи эс явалцвал тоогүй. Тэгвэл би ганцаараа туршихаас өөр аргагүй гэв. Үүнд би чи ганцаараа турших гэж үү? Солиорсон биз ээ. Хэдий явах вэ?

гэвэл Легранд үгүүлрүүн: Шөнө дуусан явах болох биз. Одоо даруй явсугай. Юу ч атугай өглөө нарнаар ирэх хэрэгтэй болно гэв. Үүнд би тийн бол хэрэв энэхүү гамшгийн явдал өнгөрч цохын хэрэг дууссаны хойно, чи шууд гэртээ ирж, миний үгийг эмчийн уг адил дагахыг надад батлан хэлнэ үү гэсэнд Легранд тэр тухай би ам өгсүгэй. Ганцхүү цаг нөгцөөлгүй эдүүгээ явъя гэв. Түүнээс миний бие өөрийн нөхрийг аргагүй дагаж одов. Легранд, Юпитер тэдний нохой бид дөрөв дөрвөн цагт гарсан бөгөөд Юпитер хадуур хүрз зэрэг бүхий л зэвсгийг үүрсэн нь өөрийн дураар ч биш шахамдлыг хүлээсэн ч биш, ганцхүү өөрийн эзний гарт тэдгээр зэвсгийг өхдөө айн болгоомжилсны учир тийнхүү ганцаар үүрэн яваа бололтой. Явах замд Юпитерийн царай нь ихэд чинэрсэн бөгөөд амандаа хараалаар бүтсэн хар цох гэж ямагт үглэнэ.

Миний бие сүүмгэр дэнлүү хоёрыг барьсан ба Легранд сайхь цохоо нэгэн ташуурын сурын үзүүрээс уяж замд ийш тийш илбэчин мэт эргүүлнэ. Эл байдал дээрээс би, миний нөхөр солиорсон болохыг лавтай мэдэж нулимс унаган алдаж арга буюу ямар нэгэн олигтой аргыг олтол түүний аясыг дагалдан түр зуур боловч сэтгэлий нь тогтоохыг эрхлэн явна. Түүнээс юуны тул явааг хэлэх газаргүй боловч дэмий л шамдан дагана. Би хэдийгээр түүнийг дагаж явавч тэр өөрийн чухал нууц явдлыг надай илэрхийгээр ер үгүүлэхгүй

асуух тухай бүр «юун болохыг бид үзнэ» гэхээс өөр үггүй явна. Тус арлыг шувтрахад бид нэгэн бяцхан завьд суун эх газрын дэнж дээр гарч баруун хойт зүгт замнан, хүний мөр огтхон ч үгүй туйлын зэрлэг цөл газраар цааш явав. Легранд маньг маш шамдамгайгаар удирдан явах бөгөөд үе үе зог тусан зогсож тэр урьд явахдаа тавьсан бололтой, ямар нэгэн зам заах тэмдгийг ажиглана. Ийнхүү хоёр цаг илүү явсаар хараахан нар шингэхийн чацуу нэгэн газар хүрвэл урьд үзээгүй, адилтгашгүй цөл газар байх бөгөөд хөлөөс орой хүртэл нягт мод хучигдсан, хэрэв мод тээглэсэнгүй бол дорхи завинд даруй асгаран нурам хад асгатай, туйлд (оройд) авиран гарч болшгүй өндөр байц хэдүйдсэн ба уулын хавцал нь зүг зүгт харанхуйлсан эргэн тойронд үнэхээр уйтгартай сүрлэг газар байв. Бнд чухамхүү хүрвэл зохих газраа авиран очвол, хадын навчин маш шигүү хэтэрхий ургасан нь, хадуураар хадаж зам эс гаргавал явахын аргагүй тул Юпитер өөрийн эзний тушаалаар тэрхүү газарт бүхий арваад царс модны дэргэд байгч туйлын өндөр алзул (Латинаар *tnlira* гэнэ. (орчуулагч)) модны ёроолд хүртэл, хадуураар нарийхан зам гаргав. Энэхүү мод бол бусдаас ялгаран үзэгдэх бөгөөд, түүний навчны сайхан ба хэлбэр дүрсийн гуа болоод гишүү мөчир нь асар дэлгэрэн намирсан зэрэг жавхлантай сайхныг үгүүлшгүй. Бид нар мөнхүү модны дэргэд хүрмэгц, Легранд, Юпитерийн зүг энэ мод өөд авирч чадах уу гэж асуухад, тэр

нэгэн зэрэг гайхсан янзтай болж, баахан дуугүй байгаад, дараагаар тэр бүдүүн модны дэргэд хүрч нарийвчлан ажигласны хойно, Вилльям авгай, Юпитер чинь ямар нэгэн өндөр модон өөд хэзээд авиран гарсаар ирсэн бишүү гэхэд, Легранд үгүүлрүүн: Тэгвэл чи аль чадахын чинээгээр дээш авирагтун. Удалгүй харанхуй болох тул юун хэрэгтэйг олж үзэхгүйд хүрнэ гэсэнд Юпитер, Вилльям авгай хаа хүртэл авирах вэ гэж асуусанд, Легранд үгүүлрүүн: Эн түрүүнд голыг дагаж авирагтун. Дараагаар хаа авирахыг би хэлж өгнө гээд энэхүү цохыг авагтун гэж мөнөөх цохыг өхөд, негр цох гэнэ ий, сайхь алтан цох уу гэж дуу алдан гэдрэг ухарч, би тэр цохыг модон дээр аваачаад яах вэ. Тэгвэл чөтгөр намайг аваачна. Би хэрхэвч түүнийг авч гарахгүй гэв. Үүнд Легранд үгүүлрүүн Чи ийм том негр байтал үхсэн гэмгүй бяцхан цохыг барихаа айна гэж үү. Чи түүний уясан оосроос нь бариад гарсугай. Хэрэв чи авч эс гарвал хүрзээр толгойг чинь хага цохино гэж зандарсанд Юпитер, та ер нь надаар яах гэсэн юм бэ гэж уцаарлаж юунд муу негрээр ямагт ийнхүү элэг барин оролдож байдаг юм бэ. Би наадаж хэлсэн билээ. Тэр цохоос хэрхэн айна. Тэр намайг яахч үгүй гээд, мөнхүү цохыг уясан сурын үзүүрээс урт зайтайгаар унжуулан барьж модон өөд авиран эхлэв. Алзул мод бол залуудаа америкийн ойн хамгийн үзэсгэлэнтэй сайхан мод мөн бөгөөд, гол нь өөгүй гилгэр ба дээр хүртэл гишүүн мөчиргүй байдаг билээ.

Ганцхүү хөгширсөн хойно буржгар холтостой болж, голд нь олон жижиг гишүү ургана. Иймийн тул түүнд авирахад чухамдаа тийм бэрхтэй биш аж. Түүнээс Юпитер мөнхүү модны бүдүүн ёроолыг гар хөлөөр чадах чинээгээр чанга хавчин авирсан бөгөөд гараар зарим нэгэн товгорыг савардаж, нүцгэн хөлөөр бусад нэгэн товгорыг гишгэж авирсаар, нэг хоёр удаа бараг унан алдаад арай гэж торж нэгэн том мөчир дээр гарч, хамаг хэргийг ялж төгссөн мэт байна. Негр хэдийгээр газраас жар далан тохойн зайтай гарсан боловч, түүнийг хамаг бэрхийг гаталж чадсан гэвэл болно. Гэтэл Юпитер өндөр дуугаар Вилльям авгай одоо би хаа авирах вэ гэж асуухад Легранд энэ талд хандаж гол салааг даган авирагтун гэж заахад негр түүний үгийг даруй дагаж нэн шаламгайлан улам улам авирсаар, эцэст бидэнд үзэгдэхгүй болон, түүний чийрэг бие нь модны шигүү навчинд далдлагдав. Энэ үе ганц, хүү дуу нь дээрээс хааяа нэг сонсдох бөгөөд одоо би хаашаа авирах вэ гэж хашгарна. Легранд чи хэдий дээр гарав гэж асуувал, учиргүй дээр гарав модны оройгоор тэнгэр тулан үзэгдэж байна гэв. Легранд тэнгэр байвал тэнгэр байгаа биз. Ганц миний хэлэх үгийг сонсогтун. Доош модны гол дагуу энэ талаар харж хэдэн мөчир өнгөрөн гарсныг тоолж хэлэгтүн гэсэнд, Юпитер нэг, хоёр, гурав, дөрөв, тав гэж тоолж би эдүүгээ энэ талд зургаан том мөчир өнгөрөөд байна гэж хашгарахад, Легранд тэгвэл

бас нэг мөчир дээш авирагтун гэсэнд нэгэн хэдэн хувь болсны хойно тэр би долоодугаар мөчир дээр авираад байна шүү гэж дуудав. Түүнээс Легранд их л сэтгэл хөдөлсөн байдалтайгаар дуу алдан чи тэрхүү мөчрийг дагаж хажуу тийш аль болохоор гадагш мөлхсүгэй. Хэрэв ямар нэг жигтэй юмыг үзвэл манд хэлэгтүн гэв. Эдгээр байдлыг би үзэж, сонсмогц миний муу нөхөр эрүүлгүй ажуу гэж эцэстэл дамжиггүйгээр мэдсэн бөгөөд тэр үнэхээр солиорсон нь илэрхий болох учир ганцхүү түүнийг гэрт нь эгүүлэн аваачихыг санаа тавин бодов. Би чухам хэрхэхийг эрэгцүүлэн байхын зуур Юпитер дуу гарч, энэ мөчир бараг бүгдээр өмхрөн ялзарсан тул цааш мөлхөхөд нэн ч аюултай байна гэв. Гэтэл Легранд хоолойг чичрүүлэн тэр мөчир нь ялзарч гэв үү. Чи юу хэлж байна гэж лавлахад Юпитер, Вилльям авгай энэ бүрмөсөн ялзарчээ. Хүн хэрэв түүний дээр авирвал даруй амь алдана гэхэд Легранд их л тэчъядан сандарч, одоо хэрхвэл зохих билээ. Аяа яах билээ гэхэд би даруй баярлаж, үг хатган хэлэх сэдэв олдохуяа, бушуу гэртээ харьж орондоо хэвтэлтэй биш үү. Одоо явъя томоотой байтугай. Орой болов. Бас ч өөрийн хэлсэн үгэндээ хүрэх хэрэгтэй гэхэд, Легранд миний үгийг өчүүхэн ч тоомсорлон хайхарсангүйгээр Юпитер, Юпитер сонсож байна уу гэж дэмий л хашгарна. Үүнд Юпитер Вилльям авгай, би таны дууг тодорхой сонсож байна гэж дээрээс хариулахад Легранд үгүүлрүүн: Юпитер ээ чи тэрхүү

мөчрийг хутгаар огтолж чухамхүү ялзарсан эсэхийг магадлан үзсүгэй гэхэд Юпитер Вилльям авгай тэр үнэхээр ялзарсан билээ гээд, бас дахин үгүүлрүүн: Тийм боловч асар ялзарсан бус тул цааш бяцхан давшиж үзвэл болох боловч ганцхүү ганцаар бус бол болшгүй гэхэд Легранд ганцаар гэнэ ий чи, Ганцаар гэж чи юуг хэлнэ гэхэд Юпитер үгүүлрүүн: Би цохтой явна шүү дээ. Энэ цох чинь туйлын хүнд цох байна. Хэрэв би түүнийг доош хаявал нэгэн өчүүхэн негрийг тэр мөчир нь даах биз гэсэнд Легранд нилээд тайтгарсан байдалтайгаар чи яасан зальтай хар золиг вэ. Юун учир ийнхүү худал хэлж байна. Хэрэв чи цохыг унагаавал толгойг чинь авна. Чи хүний үгийг сонсож байна уу? үгүй юү? гэхэд Юпитер сонсож байна. Ганцхүү та муу негрийг ингэж загнах хэрэггүй гэсэнд Легранд тэгвэл сайн. Одоо чи цохыг газар унагаахгүйгээр тэрхүү мөчрийг дагаж даахын чинээгээр цааш мөлхвөл, чиний бууж ирсэн хойно нэг мөнгөн төгрөг шагнана гэхэд Юпитер, Вилльям авгай, би үнэхээр мөлхсөөр бөгөөд бараг үзүүрт нь хүрээд байна шүү гэж хашгарна. Үүнд Легранд дуу алдан чи мөчрийн шувтарганд хүрээд байна гэнэ ий гэж лавлахад Юпитер, Вилльям авгай би бараг мөчрийн шувтраганд хүрээд байна гэсний дараа, ай, ай, ай, тэнгэр минь энэ модон дээр чинь юу байгаа юм бэ гэж орилтол, Легранд за юу байна гэж ихэд баярласан байдлаар хашгаран асуух бөгөөд, Юпитер үгүүлрүүн: Энд нэгэн хохимойн толгой байна. Ямар хүн

толгойгоо энэ модон дээр орхиод явсан юм бэ? Түүний хамаг махы нь хэрээ мөлжсөн ажуу гэсэнд, Легранд хохимойн толгой байна гэнэ ий. Тийм бол маш сайн. Түүнийг модны мөчир дээр хэрхэн тогтоосон байна. Юугаар уясан байна гэхэд, Юпитер, мэдэхгүй би сайн үзье гээд дахин үгүүлрүүн: Яасан жигтэйхэн юм бэ том хадаасаар түүнийг модон дээр яг хадаж гэв. Гэтэл Легранд, сайн сайн Юпитер ээ чи миний хэлснийг нэгд нэгээр үйлдэгтүн. Сонсож байна уу чи гэхэд Юпитер сонсож байна гэв. Үүнд Легранд үгүүлрүүн: Сайтар сонс тэр хохимойн толгойн зүүн нүдийг ол гэсэнд Юпитер за за гэсний дараа энэ толгойд нүд байхгүй юм гэхэд Легранд хар мангуу чи зүүн гар, баруун гар хоёрыг ялгаж мэдэхгүй юу гэсэнд Юпитер түүнийг би ялгалгүй яахав. Би солгой гараар түлээ хагалдаг шүү дээ гэв. Гэтэл Легранд үгүүлрүүн: Мөн, мөн чи солгой шүү дээ. Чиний зүүн нүд чинь мөн солгой гарын тал дахь нь шүү дээ. Одоо чи тэрхүү толгойн зүүн нүд бүхий талыг олно биз гээд бас олов уу, олов уу гэж шаардана. Энэ завсар нилээд удсаны хойно Юпитер асууруун: Энэ хохимойн толгойн зүүн нүд нь, мөнхүү толгойн солгой гарын талд биз дээ. Гэтэл энэхүү хохимойн толгой ер гар гүй юм байна. Гэвч би түүний зүүн нүдийг олов. Зүүн нүд нь энэ байна. Түүгээр яах вэ гэв. Легранд тэрхүү зүүн нүдээр цохыг оруулж, дээсний уртын хирээр унжуулан унагатугай. Харин түүнийг унагахдаа сайтар хянахаас гадна дээсний дээд

үзүүрийг сайнаар барьж байх хэрэгтэй гэсэнд Юпитер Вилльям авгай аа! Би бүгдийг үйлдэв. Цохыг тэрхүү нүхээр оруулан унжуулах нь нэн хялбар байна. Доош унаж байна, түүнийг харагтун гэж хашгарна. Ийнхүү ярилцаж байхын үес Юпитер ер үзэгдэхгүй бөгөөд харин түүний дээрээс унагасан цох дээсний доод үзүүрт тодорхойгоор үзэгдэх бөгөөд шингэж бүхий нарны гэрэл бидний байгаа газар дээр сүүмэлзэн байхын дотор мөнхүү цох алтан бөмбөлөг мэт гялалзана. Тэрхүү хорхой агаарт унжих бөгөөд хэрэв Юпитер түүнийг сул тавьсан бол бидний хөлийн дор унах билээ. Легранд даруй нэгэн хадуурыг авч хорхойн унжиж бүхий газрын дор эргэн тойрон гурван метр хагас газар өвсийг хадаж цэвэрлээд, Юпитер ээ, дээсийг тавьж модноос бууж иртүгэй гэв.

Түүнээс миний нөхөр мөнхүү цохын яг унасан газар дээр маш нарийвчлан нэгэн гадас шаасны хойно өврөөсөө нэгэн урт хэмжүүр гарган, модны ёроолоос уяж өнөөх гадас тийш чиглүүлэн татаж түүнийг дайруулан, тэндээс хадын навчийг Юпитер хадаж байх үе мөн зүгт тавин тохой газар татаж тэрхүү үзүүр дээр бас нэгэн гадас шаагаад эргэн тойрон дөрвөн тохой хүрээ татав. Түүнээс Легранд өөр нэгэн хүрээ авч, Юпитер бид хоёрт нижгээдийг өгөөд чадахын чинээгээр хурдан ухтугай гэв. Чухамдаа миний бие, энэ мэтийн явдалд ер дургүй бөгөөд ялангуяа энэ өдрийн ажлыг

нэн ч жигшин үзнэ. Явж ирэх замд ядарсны дээр шөнө орой болж буй нь даруй орхиж одмоор авч, ганцхүү зайлсхийхийн аргагүй бас ч хөөрхий муу нөхрийн сэтгэлийг эвдэхээс айна. Би Юпитертэй хүчин хавсарвал, тэрхүү солиорсон хүнийг гэрт аваачиж чадах боловч, тэрхүү хөгшин негрийн ааш авирыг нэгд нэгээр мэдэх бөгөөд хэрэв би ямар нэгэн зүйлд боловч түүний эзэнтэй тэмцэгч мэт болбол тэр ямагт эзнээ өмгөөлж түүнд туслах нь зайлшгүй билээ. Ердөө Леграндын ийнхүү аашлах нь, өмнө газарт булшны сан зоорь байдаг гэж өдий төдий хоосноор итгэдгийн нэгэн дамжиггүй болох ба хорхой олоод түүний хий бодлого нь хөдөлсөн буюу бас ч Юпитер мөнхүү цохыг ёстой алтан цох гэж таамаглан боддогоос болсон буюу. Энэ мэтийн зүйл түүний хэдийнээс хий бодон туналзсан сэтгэлтэй нь авалцан солиоруулж байгаа нь энэ болов уу. Тэгээд бас хөөрхий муу Легранд энэ цох бол миний зол заяаг зааж өхөөр олдсон юм гэж үгүүлдэг билээ. Үүнд би ихэд зовинон хэрхвэл зохихыг гайхсан бөгөөд эцэст түүний малтах гэсэн газрыг эрхбиш аль хурднаар шамдан ухаж, тэрхүү солиорсон хүнд үзүүлэн хий бодлогы нь дарахаас өөр аргагүй гэж шийдэв.

Дэнлүүг ноцоосны дараа бид гурав үнэхээр нэгэн чухал юмын тул санаа тавьсан байдалтайгаар ухав. Энэ үе манай байдал дүрс ба багаж зэвсгийг үзвэл, нэн ч гайхалтай сонин гэмээр бөгөөд хэрэв ямар нэгэн хүн ойр ирж харвал

манай малтаж бүхий байдал юутай жигтэй, юутай сэжиглэлтэй байсан бол.

Бид нар хоёр цаг шахам бараг завсарласангүй нүх малтав. Харилцан ярилцсан нь бага сага хамгийн ихээр манийг зовоосон нь бидний ажилд дагалдан яваа нохойн дуу бөгөөд эцэст тэр ойр хавьд хүн ирж яваа байгаа бололтойгоор хуцаж манийг нэн айлгав. Үүнд Легранд их л айсан байдалтай байсан бөгөөд харин сонсох бүр үүний улмаас сэтгэлийн өвчинтэй болсон нөхрөө гэрт нь гэдрэг аваачин одож болох болов уу гэж баярлаж авай. Эцэст нохойн дуунд Юпитер тэчъяагдахдаа нүхнээс маш сүрхий царай гарган гарч ирээд өмдний тэлээгээрээ нохойн хоншоорыг боогоод хөмсөг зангидан инээсээр гэдрэг бас малтав.

Нилээд удсаны хойно бидний ухсан нь таван тохой гүнд хүрсэн авч, ямар нэгэн булшийн сангийн ором ч үгүй үзэгдэнэ. Түүнээс бид нар түр зуур амарцгаасан бөгөөд, энэ үе миний бие манай ийнхүү нурших явдал өнгөрсөн гэж бодож байв. Легранд урамгүйгээр толгойгоо тулан юм бодож байгаад бас дахин ухав. Тэгээд бид эргэн тойрон дөрвөн тохой өргөтгөж ийш тийш нилээд туршин бас доош нь хоёр тохой нэмж малтсан нь ер юу ч үгүй болохуяа эцэст хөөрхий алт эрэгч Легранд ихэд цөхөж гашуудсан байдалтайгаар нүхнээс гарч, удаан бөгөөд дургүйгээр гадуур цамцаа өмсөн

цааш малтахыг зогсохыг завдав. Энэ үед би юу ч хэлсэнгүй. Юпитер өөрийн эзний дохиогоор багаж хэрэгслээ цуглуулан боов. Түүнээс нохойн хоншоорыг тайлж суллан дув дуугүй гэрийн зүг эргэв. Тэндээс арван хэдэн алхам явахад Легранд гэнэт өндөр дуугаар хараан, Юпитерийн зүг цовхорч зааман дээрээс нь авахуяа. Юпитер нүдээ бүлтийлгэн, амаа ангайн хүрээ газар алдаж сөгдөн унав. Гэтэл Легранд, шүдээ хавиран хоолойгоо чичрүүлж муу зальхай золиг, хараалаар бүтсэн хар негр одоо бушуу хэл чи, чиний зүүн нүд чинь аль вэ гэж зандарна. Негр түүнээс өршөө гэж айн сүрдэж Вилльям авгай миний зүүн нүд энэ гэж орилон өөрийн баруун нүдийг заан даруй түүнийг дайран занчина гэж айсан мэтээр алгаараа халхлан дарна. Тэгтэл Легранд ер нь тэгж бодсон юм. Түүний чинь мэдсэн юм. Ухай гэж хашгарч, негрийг тавин ийш тийш тэвхцэж цовхчиход түүний зарц сөгдсөнөөс босож дуугүй гөлрөн өөрийн эзэн өөд ба над руу ажиглан харна.

Түүнээс Легранд бид одоо буцвал зохино. Горьдол бас тасраагүй гэж бид хоёрыг авч гэдрэг мөнхүү алзул модны ёроолд очоод Юпитер ээ нааш ир! Тэрхүү мөчир дээр бүхий хохимойн толгойн нүүрэн тал нь гадагш хандсан байсан уу? дотогш хандсан байсан уу гэхэд Юпитер үгүүлрүүн: Вилльям авгай түүний нүүр нь гадагш хандсан байсан билээ. Тиймийн тул нүдий нь хэрээ хялбар ужжээ гэсэнд Легранд үгүүлрүүн: За чи цохоо оруулан унагаасан нүд аль бэ гэхэд Юпитер

Внлльям авгай, таны хэлснээр энэ зүүн нүд рүү нь хийсэн билээ гээд түүний баруун нүдийг заав. Үүнд Легранд тэгвэл сайн одоо дахин нэг удаа туршсугай гээд мөнөөх цохын унасныг тэмдэглэсэн гадаснаас баруун тийш гурван ямх хиртэй газар хэмжиж шинэ гадас шаагаад урьд ёсоор модны ёроолоос түүнийг дайруулан дээс татаж тавин тохой хэмжээлэн, хуучин ухсанаас нилээд метр алсалсан газар тэмдэглэв. Энэ үе би солиотой хүн бас ийнхүү нарийн ухаанаар ажилладгийг үзэв. Түүнээс тэр шинэ гадсыг тойруулан урьдхиас нилээд ихээхэн хүрээ татсаны хойно, бид хүрз барин малтаж эхлэв. Би туйлаар ядарсан боловч бодох санах минь жигтэй өөр болсон бөгөөд үүний урьд Леграндыг малт ух гэхэд нь жигшиж байсан минь эдүүгээ болив. Тэрч байтугай би эл явдалд гэнэт их л сонирхлыг тавьснаас гадна, бас ч сэтгэл гайхалтайгаар хөдөлнө. Бодвол би Леграндын тийнхүү мэргэнээр бодох санах ба ухаан сэхээ нь хурцыг үзээд түүнд автагдсан биз. Түүнээс би маш шамдан малтсан бөгөөд харин ч миний нөхөр булшны сан нээнэ гэж ямагт эрмэлзэн бүхийтэй адил сэтгэл надад бас ургав. Ийм дэмий юм миний сэтгэлд хадагдан бодогдож байгаад, бид малтсаар нэгэн цаг хагас болоход нохой дахин хуцаж сэжиглэлтэйгээр улина. Үүний урьд бол тэр дэмий л саваагүйдэх буюу уулинхайдан хуцаж байсан нь илэрхий бөгөөд харин эдүүгээ их л зэвүүн дуу гаргана. Юпитер түүний

хоншоорыг дахин боох гэж оролдвол, харин тэр өмнөөс нь хэдэрлэн цовхорч бидний малтаж бүхий нүхний дотор харайн орж ирээд галзуурсан мэтээр савраар газар маажлан самардана. Хэдхэн хормын зуур хүний ясыг хэсэг хэсгээр малтан гаргахыг бүртгэвэл хоёр хүний яс ажуу. Энэ завсар янз бүрийн төмөрлөгийн зүйлээр хийсэн товч хэд хэд ба шороо тоосонд идэгдсэн ноосон эд мэтийн юм гарав. Бас хоёр гурван хүрз шороо малтахад испанийн нэгэн том хутга хангинан гарав. Улам цааш малтвал алт мөнгөн зоос гурав дөрөв сул байхыг олов.

Юпитер түүнийг үзээд ухаан алдтал баярлана. Харин түүний эзний царай нэн ч зориг гутсан янзтай болов. Тийн байвч тэр мөн цааш ухсугай гэхийн зуур би салгалан бүдэрч унасан нь миний гутлын хоншоорт нэгэн төмөр сэнж тээглэсэн ажээ. Түүний хагас нь газар дотор далд байна. Үүнийг үзээд бид нэн шамдан ухсан бөгөөд би арван хувийн зуур ердөө үзээгүй сэтгэлийн хөдөлгөөнийг хүлээсэн билээ. Түүнээс бид нэгэн уртлаг модон авдрыг арай гэж бараг ил гаргасан нь үнэхээр сайнаар батлан тавьсан ба ялангуяа мөнгөний усан бихлорид (Хувилах ухааны тэмдэг $HgCl_2$ (орчуулагч)) буюу ямар нэгэн зүйлээр чулуужуулан бэхэлсэн ажээ. Энэ авдар бол гурван тохой хагас урт, хоёр тохой хагас өндөр төмрөөр бүслүүр бөгж хийж бэхлэн хадсан ба эргэн тойрон тоног үйлджээ. Авдрын хоёр хажууд амны орчим нь

тус бүр гурван төмөр цагираг бүхий нь бүгд зургаан хүн дамжлан авч явахын тул хийсэн бололтой.

Бид гурав хамаг хүчээ гаргаж, тэрхүү авдрыг өргөвөл уг газраас ганцхүү өчүүхэн төдий хөдөлгөхөөс яаж ч үл чадах тул ийм хүнд юмыг бид хэрхэвч аваачин чадахгүй нь илэрхий болов. Гэтэл харин завшаанд түүний хавхгийг зөвхөн хоёр хөшүүрээр цоожилжээ. Бид түүний дотроос юу гарах бол гэж ихэд чичрэн дагжин, дээр амьсгалаар айн нээмэгц тоолшгүй үнэт эрдэнийн сан манай өмнө гэрэлтэн үзэгдэнэ. Харанхуй хонгилын дотор тусах дэнлүүгийн гэрэлд овоолсон алт ба эрдэнийн чулуу гялтганан гялалзах нь нүдээр харахуйяа бэрхтэй гялбалзана. Би эдгээр үнэт зүйлийг анх үзээд хэрхэн болсноо юуны урьд үл бичнэ. Ганцхүү бусдын хэрхэн байсан байдал төлбийг үгүүлсүгэй. Легранд сэтгэл хөдөлсөндөө их л алжаасан мэт бөгөөд ганц хоёрын төдий үг үгүүлнэ. Негрийн царай нэгэн хэдэн хувь үхсэн хүний нүүр мэт хувхай цагаан болсон нь ер негр хүний зүс түүнээс цагаан болон хэрхэн болох аж. Тэр аянга буухад цочин дүйрсэн шиг зогсох бөгөөд дараагаар малтсан нүхэнд сөгдөн унаж нүцгэн гараа тохойгоо тултал сул алтны дотор шаан хутгаж биеэ угаах гэж байгаа адил загнана. Эцэст тэр хашгаран өөрөө өөртэйгөө ярьж санаа алдан үгүүлэх нь: Ай энэ нь цөм алтан цохын учир ажээ. Сайн ч алтан цох юмсанж. Хөөрхий бяцхан алтан цохыг би юунд ингэж муугаар үзлээ. Ичгүүргүй хар негр гэж

чалчина. Түүнээс миний бие энэхүү олсон юмаа эртхэн авч одсугай гэж эзэн зарц хоёрт шаардан сануулав. Эдгээр зүйлийг үүр цайхаас өмнө гэртээ аваачихгүй бол болохгүй нь, асар оройтсон учир нэн ч яравчлан амжих хэрэгтэй болов. Гэтэл авдры нь аваачихад маш бэрхтэй учир хэрхэн аваачихыг бодцогоосоор байж өдий төдий цаг нөгцөөсөн бөгөөд ухаанд ер ч арга үл сэтгэгдэнэ. Эцэст бид, авдрын доторхи зүйлийн гуравны хоёр хувийг гаргаж хөнгөлсний хойно түүнийг сая нүхнээс татан авлаа. Гаргасан зүйлийг хадын навчны дор далдлан тавьж дэргэд нь нохойг хэвтүүлэн сахиулсан бөгөөд Юпитер, манийг иртэл учиргүйгээр хэвтсэн газраас хөдөлж болохгүй, амаа ангайн хуцаж болохгүй сайхан сахиж байгтун гэж нохойд тушаал гаргав. Түүнээс бид авдрыг дамнаж гэрийн зүг маш яаран одсон бөгөөд гэрт сайнаар хүрсэн авч замд нэн зүдгүүртэйгээр явж өглөөний нэг цаг болж байхад харьсан билээ. Бид хэтэрхий ажил хийж туйлаар алжаан ядарсны тул даруйд дахин явахын тэнхээгүй болсны учир хоёр цаг хүртэл амарч бяцхан идэж уусны хойно, завшаанаар гэрт гурван тулам байсныг авч сайхь уулын зүгт дахин одов. Дөрвөн цагаас өмнөхөн мөнхүү ухсан газар хүрч үлдсэн зүйлийг туламд тус тусдаа тэнцүүгээр хуваан агуулаад малтсан нүхийг бөглөж гэрийн зүг гэдрэг замнав. Хараахан алтан ачаагаа хаяандаа буулгаж байхын үес

үүрийн бүдэг гэгээ модны үзүүр дээгүүр дорнодоос туяарч билээ.

Бид эцэстээ ядарсан авч хөөрсөн сэтгэлд нойр үл хүрэх учир гурав дөрвөн цаг тайвангүйгээр унтсан мэт болоод олсон юмаа уудалж үзэхийн тул болзоо тавьсан мэт босцогоов.

Тэрхүү авдар доторхи юм амсрыг хүртэл дүүрэн байсан бөгөөд түүнийг бүхэл өдөр дуустал ба дараахь шөнө орой болтол уудлан үзсэн билээ. Цөмийг хутган овоолж эх адаггүй агуулсан бөгөөд нарийвчлан ялган салгавал анх манай төсөвлөн бодож байснаас нэн үлэмж юм гарсан билээ. Эдгээрийг тэр цагийн ханшаар үнэлэн бодвол дөрвөн бум таван түмэн доллароос илүүгээс биш дутуугүй үнэ бүхий зүйл болно. Түүний дотор мөнгөний зүйл огтгүй цөм Франц Испани, Германийн эртний үеийн алтан зоосууд бөгөөд бас Английн куин зоос хэд ба урьд ер олж үзээгүй ямар нэгэн балар цагийн зоос мөн байна. Бас үсэг нь танигдахгүй болтол элэгдсэн хэдэн том зоос байна. Түүний дотор америкийн зоос нэг ч үгүй болохоос гадна хамгийн бэрх байсан нь эрдэнийн чулууны өртгийг үнэлэн ядсан билээ. Түүний дотор очир алмааз бий бөгөөд нэгэн хэдэн нь онц том сайхан, бүгд нэгэн зуун арав болох нь тэдэнд жижиг нь нэг ч үгүй гал мэт бадарсан бадмаараг арван найм. Гайхамшигт сайхан нэл эрдэнэ гурван зуун арав. Биндиръяа хорин нэг. Увал нэгийн

хамт байв. Эдгээр чулуунуудыг шигтгээтэй байсан эдлэлээс нь салгаад авдарт сул хаясан бөгөөд, тэдний суурь нь нөгөө алтан эдлэлийн дотор байх нь танигдахгүй болгохын тул алхаар балбан эвдэлжээ. Тэдгээрээс гадна сайхан цул алтан чимэг эдлэл маш олон бөгөөд алтан бөгж ба ээмэг хоёр зуу орчим бас хүзүүнд зүүх үзэсгэлэнтэйгээр үйлдсэн алтан оосор гуч байсан шиг санагдана. Маш том бөгөөд хүнд алтан загалмай наян гурав, онц үнэ бүхий алтан Бойпор тав, үзмийн модны олон навч ба согтууран найрлагчдын дүрсийг урлан үйлдэж чимсэн архины том алтан завъяа нэг, алтаар гоёмсог сайхан үйлдсэн сэлмийн бариул хоёр байсан бөгөөд бас бус олон жижиг зүйл байсныг мартжээ. Эдгээр үнэт зүйлийн хүнд нь гурван зуун хорин пунд болно. Үүнд нэгэн зуун жаран долоон сайхан алтан цаг байсныг оруулаагүй бөгөөд тэдний дотроос гурав нь тус бүр таван зуун долларын үнэ элбэг хүрнэ. Эдгээр цагуудын олонхи нь хуучны эдлэл бөгөөд он удсан учир их багаар зэвэрч, явахгүй болон, үнэгүй болсон боловч цөмөөрөө эрдэнийн чулуугаар чимсэн үнэт гэртэй болно. Тэр шөнө бид нар хайрцгийн доторхи бүхий л зүйлд бүтэн хагас сая долларын үнэ зохиосон билээ.

Хожим эдлэлийн зүйл ба эрдэнийн чулууг худалдахад ганц хоёр зүйлийг өөрсдийн хувьд үлдээсэн тул бусдыг мөнөөхөн дурдсан үнэнд хүргэж хараахан чадсангүй билээ.

Үгүүлэх нь: Бид олсон зүйлийг байцаан үзэж дууссаны хойно, хөдөлсөн сэтгэл нилээд тайтгаран тогтож байхын үе, миний бие энэхүү нарийн нууц зүйлийг хэрхэн мэдсэнийг гайхан сонсохыг хүлээн ядаж бүхий байдлыг Легранд үзээд түүний аливаа учир шалтгаан ба оньсого мэт зүйлийг над нэг нэгээр тоочсон нь:

Тэр орой миний цохын дүрсийг зурсан балархай хуудсыг чамд өгч үзүүлэн байсныг санана уу. Чи түүнийг үзээд хохимойн толгойн адил болжээ гэж надад хэлсэнд би уурласан шүүдээ. Чамайг тийнхүү хэлэхэд би анхандаа хошигнож байна гэж бодсон боловч дараагаар тэрхүү цохын нуруун дээр толбо бүхийг санаад чи түүнийг хохимойн толгойтой адил гэх нь бас ч аргагүй гэж бодов. Хэдийгээр тийм байтугай ч би өөрийгөө сайн зурагч гэж бодох атал чи тийнхүү элэг барьсанд тэчъядсан бөгөөд, чамайг тэрхүү саарийг над эгүүлэн өхөд ундууцсандаа даруй урж галд хаяхыг завдсан билээ гэхэд саарь гэж өнөөх хэсэг цаасыг хэлж байна уу гэж лавлан асуувал Легранд үгүүлрүүн: Тиймээ тэр нь бараг цаас мэт бөгөөд анханд би ч цаас гэж бодож байсан билээ. Гэвч би түүний дээр зурж байхдаа тэр нь нэгэн хэсэг маш нимгэн саарь байна гэж даруй мэдсэн билээ. Тэрхүү саарь маш их хир буртаг болсон байсныг ч мэднэ. Түүнийг би базаж тас татах гэтэл миний цох зурсны тэнд үнэхээр нэгэн хохимойн толгойн дүрс зэрэвдхийн

үзэгдэхүйеэ, гэнэт гайхсан бөгөөд нэгэн зэрэг би түүний учрыг олж ядлаа. Хэдийгээр түүний ерөнхий байдал нь төсөөтэй гэвч миний зурснаас тун өөр нэгэн зүйл байв. Түүнээс би тэр даруйд нэгэн гэрэл авч байшингийн нөгөө буланд сууж тэрхүү саарийг нарийнаар шинжин үзсэн минь тэр бүлгээ. Түүнийг эргүүлэн үзмэгц ар талд нь миний зурсан зураг уг ёсоор байна. Анх удаа би цох зурсан саарийн ар талд нэгэн хохимойн толгойн зураг яв цав тохиолдсон бөгөөд бас ч хэмжээ нь нэгэн адил болохыг үзэж ийм хоёр адилхан жигтэй юм нэгэн дор тохиолдсоныг ихэд гайхсан бөгөөд, ер ийм тохиол байх нь их л жигтэй. Эдгээр ойлгогдохгүй зүйлийн учир шалтгааныг олж ядан, зүйл бүрээр эрэгцүүлэвч ямагт төөрөх тул нэгэн үе өвчинтэй мэт болов. Түүнээс би хий гайхахаа зогсож түүний тохиолдсоныг улам улмаар өөрөөр бодож үзсэн бөгөөд анхан намайг хорхой зурахад тэрхүү саарь дээр өөр зураг ер байсангүй болохыг тодорхойгоор батлан тэмдэглэв. Би мөнхүү саарь дээр хорхой зурахын тул буртаггүй цэвэр зайг зрж хоёр талы нь ээлжлэн эргүүлж сайнаар ажигласан минь дамжиггүй билээ. Тэр цагт хохимойн толгойн дүрс мөнхүү саарь дээр байсан бол зайлшгүй үзэгдэх байсан. Ийм учраас түүнд байгаа ямар нэгэн нууц учрыг олж огт эс чадав. Гэтэл миний тархины хамгийн алслагдсан өнцгөөс тэр үдшийн сонин явдал юу билээ гэж галт хорхойн цог мэт өчүүхэн гэрэл сүүмэлзмэгц даруй босож саарийг

хайрцагт агуулан цоожлоод ганцаар болтлоо цааш эрэгцүүлэн бодохыг зогссон билээ,

Түүнээс чамайг явж, Юпитерийг үхширтэл унтсаны хойно би энэ хэргийг тусгай журамтай аргаар судалсан юм. Үүнд юуны урьд тэрхүү саарийг анх хэрхэн олж авснаа эрэгцүүлэв. Юпитер бид хоёр мөнөөх цохыг тус арлаас баруун этгээдэд нэгэн миль хирийн зайтай, усан халих хязгаараас арай дээгүүр эх газрын хөвөөнөөс олж авсан билээ. Түүнийг би хуруугаараа чимхэн барихад тэр айхтар хазсанд газар алдсанд, юпитер мөнхүү цохыг нүцгэн гараараа барихыг айн болгоомжилж түүнийг жийрэглэхийн тул нэг хэсэг хуудас буюу ямар нэгэн юмыг эргэн тойрон бэдэрсэн нь энэ үе сайхь саарийг цаас гэж юпитер харсан ба би ч мөн олж үзэв. Түүний ихэнх нь элсэн дотор булагдаж зөвхөн нэг булан нь цухуйж байсан билээ. Үүний ойр газар нэгэн завийн цээжний хагас хэвтэж байгаа харагдсан бөгөөд үзэхэд түүний мод ихэд ялзарсан нь маш удаан хэвтсэн нь илэрхий байсан билээ.

Түүнээс юпитер тэрхүү саарийг авч цохыг ороогоод надад өгсөн юм. Тэндээс удалгүй бидний гэдрэг буцаж явах замд Лейтенант Гэ тохиолдсонд мөнхүү цохыг үзүүлсэнд тэр боомтын газар аваачихыг гуйснаар би зөвшөөрөн өгсөн нь тэр түүнийг нүцгэнээр өвөрлөж одоход, цохыг жийрэглэж барьсаар явсан цаас миний гарт хоцорсон билээ. Лейтенант

бол түмэн бодисын зүйлийг их л сонирхдог хүн тул надаас тийм олз олсон нь эцэст намайг өхөө буцах магадгүй гэж айн сандрахдаа цохыг тийнхүү нүцгэнээр өвөрлөн явсан биз. Түүнээс би мөнөөх саарийг дэв дэмий өвөртөө хийжээ.

Тэр үдэш цох зурахаар ширээний дэргэд очоод, байдаг газраас цаас олсонгүйг чи мэднэ. Шургуулганд хүртэл эрээд юу ч олсонгүй билээ. Түүнээс би өвөртөө нэгэн хуучин захиа байсан шиг санаад тэмтрэхэд, харин мөнхүү саарь өртжээ. Би түүнийг тэгж олсноо ихэд гайхсан тул тэр миний гарт хэрхэн орсны тухай нэгд нэгээр хэлнэ.

Чи намайг хий бодол төрж гэж санах биз. Гэвч би хэдэн зүйлийн нөхцөлийг холбогдуулан хянасан юм. Би хоёр зүйлийг барилдуулан нэгэн ихээхэн зүйлийг томъёолсон бөгөөд далайн хөвөөн дээр нэгэн завь хэвтэж байсан. Түүний ойроос энгийн цаас биш дээр нь хохимойн толгой зурсан нэгэн хэсэг саарь гарчээ. Үүнд ямар холбогдол байна гэвэл хохимойн толгой нь далайн дээрэмчний сүлд тэмдэг болохыг хэн бүхэн мэдэх бөгөөд бусдыг довтлох бүрдээ хохимойн толгой зурсан тугийг хийсгэж явдаг юм.

Тэр хуудас бол цаас биш саарь болохыг нэгэнт үгүүлсэн билээ. Саарь бол бөх болоод бараг хувирдаггүй буюу түүн дээр ерийн бичиг ба зургийг бичих зурахад тохиромжгүй тул онц чухал бус зүйлийг бичих зурах нь нэн ховор билээ. Энэ мэтээр шинжлэн үзвэл хохимойн толгойн

зургийн дор ямар нэгэн учиртай чухал зүйл байлтай гэж сэтгэгдэв. Ялангуяа саарийн хэлбэр хэмжээгээр үзвэл мөн ч тийнхүү бодолтой бөгөөд хэдийгээр нэг өнцөг нь ямар нэгэн тохиолоор тасарсан байвч анханд тэр уртлаг хэлбэртэй байсан нь мэдэгдэнэ. Энэ мэтээр үзвэл дурсгал болгон удаан хадгалах ямар нэгэн сануулга буюу тэмдэглэлийг бичих зурвастай яг адил байгаа юм гэв. Үүнд би цохиж асууруун: Чи тэрхүү саарь дээр цохыг зурж байхад, хохимойн толгойн зураг байгаагүй гэж хэлсэн биш үү? Тийнхүү чамайг цохыг зурсны хойно хохимойн толгойн дүрс, саарь дээр бий болсон гэж өөрөө хэлэх гэтэл завь ба хохимойн толгой хоёрын хооронд холбогдол байж хэрхэн болном гэж асуувал Легранд үгүүлрүүн үүний дотор их л нууц зүйл оршиж байна. Тийм боловч би түүнийг хялбараар тайлсан юм. Би өөрийн батлан санаснаас өөр арга олсонгүй. Анх цох зурахад саарь дээр хохимойн толгойн дүрс байсангүй нь магад юм. Түүн дээр зурж төгсмөгц чамд өгөөд гэдрэг эргүүлэн автал ямагт хойноос нь харж ажигласаар байсан билээ. Түүнд чи хохимойн толгой зурсангүй нь илэрхий. Бас ч өөр зурах хүн манай байшинд байсангүй билээ. Энэ мэтээр түүнийг хэн ч зурсангүй бөгөөд гэтэл хаанаас бий болов.

Ийм учраас, тэр завсрын тохиолыг нэгд нэгээр нарийвчлан бодов. Тэр өдөр маш хүйтэн (ямар нэгэн ховор шалтгаан болжээ) байсан. Бас тулга дээр гал бадарч байжээ.

Би галын цучилд дулаацаж, ширээний дэргэд сууж байсан. Чи нэгэн сандлыг тулгатай бур шахуу тавин суусан. Түүнээс би саарийг чиний гар дээр тавимагц чи үзэх гэтэл гаднаас нохой орж ирэн, мөрөн дээр чинь цовхроход, солгой гараараа түүнийг сэжин нудрахдаа саарь барьж байсан баруун гараа, санамсаргүй өвдөг завсраа оруулж саарийг галын дөл дотор оруулах шахсан бишүү. Би тэр юмыг түлүүзэй гэж чамд сануулан хэлсүгэй гэхийн завсар чи гараа татаж аван зургийг үзсэн билээ. Эдгээр тодорхой байдлыг нэхэж санан бодвол саарь дээр хохимойн толгойн зураг гарсан нь галд халсандаа илэрсэн нь дамжиггүй гэж шийдэв. Хувилах ухаанаар найруулсан зүйлээр цаас буюу саарь дээр ганцхүү галд халсны хойно ил үзэгдэхээр бичих арга эртнээс байсныг чи тодорхойгоор мэднэ. Хаан (Хувилах ухаанаар найруулсан усны нэр латинаар regia гэнэ. (орчуулагч)) усанд цаффрыг уусгаж дөрвөн хувь усаар шингэтгэвэл ногоон өнгөтэй болно. Кобальтыг (Хувилах ухааны тэмдэг Co (орчуулагч)) шүүгийн хүчилд хольж уусгавал улаан өнгөтэй болно. Ийнхүү бүтээсэн будгаар саарь дээр бичээд хөргөж хатаавал үсэг нь удалгүй буюу нилээд удаад үзэгдэхгүй болох бөгөөд хожим халаавал үсэг нь дахин илэрдэг юм. Түүнээс би хохимойн толгойн дүрсийг нарийнаар ажигласан бөгөөд түүний гадаад ирмэг ба ялангуяа цаасны шижүүр талын ирмэгээр зураг нь нилээд тодорхой үзэгдэнэ. Энэ нь

тэрхүү саарь халсан нь дутмаг буюу эсвэл нийлэнхүйдээ тэгшгүй халсны учир буюу. Иймийн тул би даруй нэгэн гал ноцоож түүний дүрэлзсэн дөлөнд саарийг тал бүрээс халаавал, эхэнд хохимойн толгойн зургийн балархай зураас нь бага сага тод болов. Гэтэл түүнийг бас халаавал, мөн зурвас хуудсан дээр хохимойн толгой зурсан өнцгийн нөгөө эсрэг үзүүрт нэгэн юмны дүрс бүрэлзэн илэрч үзэгдсэнийг би анханд ямааны дүрс гэж харав. Дараагаар сайтар шалган үзвэл харин нэгэн ишиг (ишгийг англиар kid гэнэ)-ний дүрс ажуу гэв. Үүнд би ихэд инээж бүтэн хагас сая доллар гэгч нь их үг тул би хэрхэн түүгээр наадам үзэн чамайг сонжиж болно, Гэтэл чи үүнийг гуравдугаар нөхцөл болгоно уу. Далайн дээрэмчин ямаа хоёрын хооронд ямар холбогдол байх аж. Далайн дээрэмчин ямаагаар юу ч хийдэггүй бөгөөд ямаа нь хөдөөний аж ахуйд хамаарна гэсэнд Легранд үгүүлрүүн: Би түүнийг ямаа биш учрыг хэлсэн бишүү гэв. Үүнд хэдийгээр ишиг ч гэсэн ямаанаас ялгал юу байх аж гэтэл, Легранд үгүүлрүүн: Ямаа ишиг хоёр бараг адил юм. Гэвч бүр тийм биш. Далайн онгоцны дарга Кид (Англи үг. Монголоор ишиг гэсэн үг. (орчуулагч)) (kid) гэхийг чи сонссон биз. Би тэр ишгийн дүрсийг үзмэгц энэ нь гарын үсгийн оронд тавьсан үгийг төлөөлсөн тэмдэг буюу зураг бичиг гэж ухаарсан бөгөөд юуны учир гарын үсэг гэж хэлэв гэвэл саарь дээр түүний ишгийн дүрсийн байгаа газраар тийнхүү бодов. Хохимойн

толгой нь түүний ташуу эсрэг өнцөгт тамга буюу сүлд тэмдгийн янзтай байлаа. Харин тэр хоёроос өөр юу ч үгүй, миний гол болгон хүсэлхийлсэн бичгийн зүйл дутагдсанд их ч гашуудав гэхэд, чи түүний тэмдэг гарын үсэг хоёрын хооронд бичиг байна гэж бодов уу? гэвэл Легранд үгүүлрүүн: Тийм ч тийм ээ. Чухамдаа надад ямар нэгэн ерийн биш зол заяа учралтай гэж бодогдох болсон бөгөөд юунаас тийнхүү бодогдох болсноо би өөрөө гайхна. Энэ нь ердөө хоосон хүслээс үүссэн байж болно. Гэвч Юпитер сайхь цохыг үнэхээр алтан цох гэдэг мангуу үг миний хий бодлыг нэн ч биелүүлэн догдлуулсан гэлтэй. Түүнээс гадна бүхий л тохиол гэнэт нийлсэн нь ч ерийн бус тун гайхалтай ямар ямар тохиолууд нийлснийг чи ч ажиг авсан бөгөөд эдгээр явдал нь. цөм ганц нэгэн өдөр болсон билээ. Жилд тийнхүү онц нэгэн хүйтэн өдөр болсон. Түүнээс тэр өдөр эрхгүй гал түлэх хэрэгтэй болсон. Гал (Сэлливан арал бол маш дулаан газар болох нь гал толэх учрал нэн ховор тохиолддогийн учир буюу (орчуулагч)) түлсэнгүй болоод, чамайг зургийг үзэх үес нохой орж ирээд хөдөлгөсөнгүй бол тэр хохимойн толгойн дүрсийг хэрхэн олж үзэх билээ. Түүнийг эс үзсэн бол булшийн санг хэрхэн олж авах билээ гэв. Үүнд би чухам учрыг сонсохыг ихэд хүсэх тул цааш ярина уу гэсэнд Легранд, за за гээд үгүүлрүүн: Кидийн тухай ба тэр Атлантын гадаад далайн хөвөөнд ямар нэгэн газраа мөнгө булсан гэж маш олон

зүйлээр хэлэлцэх цуу үгийг сонссон биз. Энэхүү цуу үг нь удтал үргэлжлэн дэлгэрсэн тул бас ч нэгэн ортой зүйл байлтай учир эл булшийн сан ямар нэгэн газар байсаар байгаа аж гэж санагдав. Хэрэв Кид дээрэмдсэн олзоо нэгэн зуур нуун далдлаад гэдрэг гарган авсан бол одоо олны цуу дамнан хэлэлцэж бий үг, ийм байхгүйсэн. Ердөө булшийн сан Эрэгчдийн тухай үгүүлэлдэхээс бус тэр олсон гэж хэлэлцэх нь үгүй. Хэрэв далайн дээрэмчид өөрсдийн мөнгийг гэдрэг авсан бол бас ч тэр явдал мартагдсан байх ёстой. Бас цааш эрэгцүүлбэл Кид юм хаа булсны тухай тэмдэглэлээ гээгдүүлсэн буюу ямар нэгэн учраас гэдрэг гарган авахын аргагүй болсон мэт. Түүнээс бусад нөхөр сэлтдээ мэдэгдэж булш эрсэн болох ба эцэст олж ядахдаа сурагласанд тэр тухай олон цуу үг тарсан аж гэж бодов. Далайн хөвөө дагуу маш их булшийн сан бий гэж чи сонссон уу гэхэд, би үгүй учрыг хэлэв. Легранд үгүүлрүүн: Кидийн дээрэмдэн овоолсон эд нь хязгаарлашгүй болохыг хэн бүхэн мэднэ. Эдгээр баялаг эдүүгээ хүртэл газар дор энх амгалнаар оршсоор бөгөөд энэхүү олохын аргагүй болсон зүйлийн хадгалагдан бүхий газрыг зааж өх эрдэнэ мэт саарийг олж аван, бараг түүнийг үзэхэд хүрсэн учрыг үгүүлбэл, чи их л гайхах биз ээ гэв. Үүнд би хэрхэн мэдэв гэвэл Легранд бас үгүүлрүүн: Түүнээс би саарийг галд бас дахин нэн нэн халаавч ер юу ч үзэгдэхгүй болохуйяа энэ нь уг саарь их хиртэж буртаг болсноос дээрх

зүйл нь илрэн эс гарах аж гэж сэтгэж даруйд бүлээн усаар түүнийг сайтар угаан цэвэрлээд тугалга гүйлгэсэн тавгийн дотор хохимойн толгойн дүрс бүхий талыг доош харуулан агуулж модны нүүрс улайлгасан тулгын дээр тавин, бас халаав. Нэгэн хэдэн хувийн хойно мөнхүү таваг халсанд сайхь саарийг үзвэл түүний дээр хэд хэдэн газар тооны тэмдгүүд хөндлөн зэрэгцэн үзэгдэхэд гэнэт баярласан нь үгүүлшгүй. Тэгээд түүнийг бас дахин нэгэн зуур тавгийн дотор хийгээд гэдрэг авсанд ийм тэмдгүүд илрэн гарсан билээ гэж мөнөөх саарийг гаргаж галд халаагаад над өхийг авч үзвэл хохимойн толгой ишгийн дүрс хоёрын хооронд улаан бэхээр бичсэн тэмдгүүд нь:



$53 \frac{1}{+} \frac{1}{+} + 305) 5^* ; 4826) 4 \frac{1}{+} .) 4 \frac{1}{+} ; 803^* ; 48 + 8 \cdot \lfloor 60))$
 $85 ; 1 \frac{1}{+} (; \frac{1}{+} * 8 + 83(88) 5^* + ; 43(; 88 * 93^* ? ; 8) * \frac{1}{+} (; 485) ;$
 $5^* + 2 : * \frac{1}{+} (; 4955^* 2(5^* - 4) 8 \cdot \lfloor 8^* ; 4069285) ; 5 + 8) 4$
 $\frac{1}{+} \frac{1}{+} ; 1(\frac{1}{+} 9 ; 48081 ; 8 : \frac{1}{+} 1 ; 48 + 85 ; 4) 485 + 528803 * 81 (\frac{1}{+}$
 $9 ; 48 ; (88 ; 4 (\frac{1}{+} ? 34 ; 48) 4 \frac{1}{+} ; 151 ; : 188 ; \frac{1}{+} ? ;$



ийн буюу. Үүнийг би үзээд түүнд эгүүлэн өгч хэлсэн нь, ер би бас л учрыг олохгүй байна. Энэ оньсого мэт юмыг тайлбал Кулкондын (Эдүүгээ Энэтхэгийн хийдэрбад гэдэг мужид бүхий эрт цагт алмас зэрэг эрдэнийн чулуу ба алтаар туйлын баялаг байсан нэгэн хотын нэр болно. (орчуулагч)) хамаг эрдэнэсийг шагнал болгон өгнө гэсэн ч би, хувьд хэрхэвч

тайлан чадахгүй болно гэвэл, Легранд за хаанаас үүнийг анх харахад бэрхтэй мэт үзэгдэвч чухамдаа тийм биш билээ. Эдгээр тоо ба тэмдгүүд нь нэгэн нууц үсэг гэж хэн ч болов ойлгох биз. Бас ч Кид бол хүний олж ядмаар тийм айхтраар үсгийг тоогоор төлөөлүүлэн зохиохуйц чадвартай хүн биш гэж санана. Түүнээс тэр нууц бичиг нь зөвхөн бүдүүлэг хүмүүс түлхүүргүйгээр тайлж чадахгүйн төдий ерийн нэгэн хялбархан нууц бичиг гэж үзэв гэхэд тэгээд чи түүнийг үнэхээр тайлсан гэжүү? гэж асуувал Легранд үгүүлрүүн: Энэ нь маш хялбар хэрэг. Би түүнээс мянган хувь хэцүү зүйлийг тайлж байсан юм. Аливаа нэгэн учир шалтгаанаар ба ялангуяа миний ухаан энэ мэтийн оньсгонд их ч гүйдэг учир, дамжиггүй тайлбарлах гэсэн бөгөөд ер ч хүний хурц ухаанаар зохиосон зүйлийг мөнхүү хурц ухаанаар тайлж үл болох юун. Нэгэн хамт холбон уншиж болохуйц тэмдгүүд байхыг үзээд түүний учир утгыг олоход бэрхгүй гэж бодлоо.

Энэхүү зүйл дээр ба ердөө ямар нэгэн нууц бичгийг тайлахад юуны урьд ямар хэл дээр бичсэнийг мэдэх хэрэгтэй буюу юу гэвэл хэдийгээр энгийн нууц бичиг гэвч тайлахын гол журам түүнтэй холбогдож, нэгэн тусгай хэлний бодлогод долдойдно. Энэ нууц бичгийг чухамдаа аль болох хэлүүд дээр туршин үзвэл болох боловч ганцхүү үүн дээр гарын үсэг нь тэр мэтийн нуршуудлыг аяндаа орхиулав. Юу гэвэл Кид гэдэг овгийн нэр байсан нь зөвхөн англи хэл дээр болохыг

заажээ. Хэрэв тийм нэр байсангүй бол эрт цагийн далайн дээрэмчин нар нууц зүйлээ испани Франц хэлэн дээр бичиж байсныг санаж тэдгээр хэл дээр турших байсан билээ харин эцэст дээр дурдсан ёсоор англи хэлээр тайлахыг шийдэв.

Чиний үзсээр тэр нууц бичгийн үгүүдийг тасалсангүй байна. Хэрэв тэр тасалгаатай бол их л хялбар байхсан. Тиймийн тул би түүний дотроос ганц үсгээр бичигдэх А (Энэ нь Англи үг. Монголоор нэг сайхан өдөр, нэг хэдэн хүн, Нэг их далай гэх мэтийн ярианд хэрэглэдэг «Нэг» гэсэн үгтэй адил болно. (орчуулагч)) (нэг) буюу I (Энэ нь Англи үг. Монголоор «Би» гэсэн үг (орчуулагч)) гэх мэтийн богино үгийг юуны урьд олж авбал ганц нууц бичгийг тайлахын үүд нээгдэнэ гэж шийдэж эхлэв. Гэтэл үг үгийг хооронд нь зай гаргалгүйгээр үргэлжлэн бичсэн болох нь түүний дотроос нэн тэргүүнд хамгийн олон хэрэглэгдэх үсгийг, дараагаар хамгийн цөөн хэрэглэгдэх үсгийг ялган танихыг эрхлэв. Түүнээс бүхий л тэмдгийг тоолж үзвэл түүний дотор

8 ийм тэмдэг 33 удаа бичигджээ.

; ийм тэмдэг 26 удаа бичигджээ.

4 ийм тэмдэг 19 удаа бичигджээ.

$\frac{1}{+}$ ба) ийм тэмдэг 16 удаа бичигджээ.

* ийм тэмдэг 13 удаа бичигджээ.

5 ийм тэмдэг 12 удаа бичигджээ.

6 ийм тэмдэг 11 удаа бичигджээ.

- (ийм тэмдэг 9 удаа бичигджээ.
- + ба 1 ийм тэмдэг 8 удаа бичигджээ.
- 0 ийм тэмдэг 6 удаа бичигджээ.
- 9 ба 2 ийм тэмдэг 5 удаа бичигджээ.
- : ба 3 ийм тэмдэг 4 удаа бичигджээ.
- ? ийм тэмдэг 3 удаа бичигджээ.
- II ийм тэмдэг 2 удаа бичигджээ.
- ба . ийм тэмдэг тус бүр 1 удаа бичигджээ.

Тэмдгийг олон цөөнөөр хэрэглэсэн байдал ийм бөгөөд олноор хэрэглэгддэг үсгийг дэс дараалбал англи үгэнд хамгийн олон хэрэглэгддэг е түүний дараагаар a o f d h n r s t u y c f g l m w b k p q x z үсгүүд орно. Ийм бөгөөд е үсэг нэгэн үгүүлэлд хамгийн олон хэрэглэгддэг үсэг мөн учир иймд ерийн нэгэн саналаас баримттай үндэс нь гарч ирлээ. Энэ мэтийн зүйл дээрээс хүснэгт утга илэрхий. Харин чухамхүү нууц бичиг дээр олонт нурших хэрэгтэй тул сайхь тэмдгүүдэд хамгийн олон бичигдсэн 8 гэсэн тэмдэг нь е гэсэн үсгийг төлөөлсөн бололтой. Бас магадалбал англи үгэнд е үсэг нэг дор давхарлах нь олон бөгөөд жишээлбэл: meet, fleet, speed, seen, deen, agree гэх зэрэг буюу. Түүнчлэн мөнөөх тоогоор үйлдсэн нууц бичиг охор атал түүний дотор 8 гэсэн тэмдэг таван удаа давхарласан тул 8 гэсэн нь е үсгийг төлөөлсөн тэмдэг болох нь зайлшгүй. Иймийн тул 8 гэснийг е үсэг гэв. Ердөө англи үгэнд the (Энэ нь англи хэлэнд биет нэр үгийн

өмнө орж явах гишүүн юм. (орчуулагч)) гэдэг үг маш олон хэрэглэгддэг бөгөөд нарийвчлан ажиглавал 8-аар дуусаж зэрэгцсэн хоёр тэмдгүүд түүний дотор олонтой тохиолдоно. Дэс дараалан үзвэл тийнхүү зэргэлсэн ; 4 8 гэсэн тэмдэг тав зургаан удаа байх тул түүнийг the гэсэн үг гэж болох учир;-ийг t 4-ийг h 8-ыг e гэж тэмдэглэсүгэй. Үүнээс нууц бичгийг тайлахад нэгэн ихээхэн алхам давшив.

Гэтэл ийнхүү нэгэн үгийг олсоор нилээд чухлыг магадлан чадах бөгөөд юу гэвэл түүгээр бусад үгүүдийн эх ба адгийг олж болно. Жишээлбэл дээр тохиолдсон байдлаар ; 4 8 гэдэг тэмдэгтэй холбосон тэмдгийг үзвэл нууц бичгийн бараг эцэст мөнхүү ; 4 8 гэсэн тэмдэг (; 4 8) дараа ; гэдэг тэмдэг байх нь 1 үсгээр эхэлсэн нэгэн үг байхыг илэрхийлсэн бөгөөд, түүний дараа тохиолдох басхүү нэгэн ; 4 8 гэсэн тэмдгийг хүртэл нэгэн үг бүтээхэд үл мэдэгдэх тэмдэг даруй зургаа болох үүнд ямар үсгийг төлөөлсөн болохыг эс мэдэх тэмдгийн оронд зай үлдээж тайлбал тэрхүү нэгэн үгийн үүсэл нь ийнхүү гарч ирнэ.

t-eeth

Ийнхүү үзвэл үүний эцсийн th гэсэн хоёр үсэг нь t-гээр эхэлсэн үгний үргэлжлэл биш харин бас нэгэн үгний эх гэж илэрхий мэдэгдэх бөгөөд юу гэвэл англи үгүүдийг цагаан толгой дараалан бүртгэвэл t-гээр эхэлж нэгэн үсэг

завсарлаад дараа нь хоёр e орж бас th залгах үг ергүй билээ.

Тиймийн тул эцсийн th үсгийг орхиж

t-ee

гэснээр дан нэг үг болгохыг мөнхүү цагаан толгойгоор дараалан туршвал

tree

гэсэн үг (Энэ нь англи үг. Монголоор мод гэсэн үг. (орчуулагч)) гэж тайлж болмоор буюу. Иймийн тул (тэмдгээр г гэсэн үсгийг төлөөлүүлсэн болохыг олж мэдсэн бөгөөд, өмнөх гишүүнтэй холбовол the tree «тэр мод» гэсэн үг юм. Түүнээс цааш ; 4 8 (the) гэсэн тэмдэг хүртэл холбосон хэдэн тэмдгүүдийг жагсаан үзвэл.

the tree с $\frac{+}{|}$? 3 4 гэсэн буюу. Үүний тайлбар олсон тэмдгүүдийг үсгээр оруулан жагсавал: the tree thr $\frac{+}{|}$? 3 h the гэжээ. Үүнд байгаа тайлаагүй тэмдгийн оронд зай гаргаж цэг тавивал:

the tree the---h the

гэсэн болохыг үзэж, тус тус зайд гурван үсэг нөхөж нэгэн үг болохыг эрэгцүүлбэл гэнэт through (Энэ нь англи үг. Монголоор дайруулан (нэвт) гэсэн үг (орчуулагч)) гэсэн үг санаанд орж ирсэнд $\frac{+}{|}$? 3 эдгээр гурван тэмдгээр oug эдгээр гурван үсгийг төлөөлснийг олж мэдэв. Бас мөнхүү нууц бичиг

үгний холбоогоор нь улмаар хуваан ажиглавал хуудасны бараг эхэнд

8 3 (8 8 гэсэн тэмдэг буюу.

Үүнийг дээр олсон тайлбараар орчуулбал degree гэсэн толгойгүй үг гарах нь degree (Энэ нь англи үг. Дэлхийн бөмбөрцгийн гурван зуун жар хоногийн хувиарыг хэлжээ. (орчуулагч)) гэсэн үг болох нь зайлшг үй учир + гэсэн тэмдэг нь d гэсэн үсгийг төлөөлсөн болохыг олж мэдлээ. Энэхүү degree гэсэн үгнээс дөрвөн үсгийн цааш

; 4 6 (; 8 8 * гэсэн холбоо үг байх нь тайлсан үсгүүдийг төлөөлүүлэн тавьж үл тайлсныг зай гарган үзвэл

th-ree-

Ийм болох нь thirteen (Энэ нь англи үг. Монголоор арван гуравдугаар гэсэн үг. (орчуулагч)) гэсэн үг даруй мөний тул * 6 энэ хоёр тэмдэг нь i n хоёр үсэг болохыг олж мэдэв. Нууц бичгийн эхэнд бүхий зэрэглэсэн тэмдгүүдийг үзвэл:

$$5 3 \frac{1}{+} \frac{1}{+} +$$

Үүнийг дээр үйлдсэн ёсоор үсэгчилбэл

good (сайн)

гэсэн үг болох нь түүний эхний 5 гэсэн тоо нь чухам юуг төлөөлсөн болохыг зэрэгцүүлбэл английн үгүүлэл буюу үгийн эхэнд ямагт явах A (Үүнийг дээр тайлбарласнаар үзнэ үү. (орчуулагч)) гэсэн үг яв цав мөн болох учир тэр нь A гэсэн үг болохыг танив.

Энэ мэтээр цааш сурвалжлан олсон тайлбаруудыг
самуурахгүйн тул юуны урьд сийрүүлэн бичвэл

5 - a

+ - d

8 - e

3 - g

6 - i

4 - h

* - n

$\frac{1}{+}$ - o

(- r

; - t

Ийн буюу. Арав илүү үсгийг энэ мэт аргаар тайлж чадсан бөгөөд түүнээс бусдыг цаашид уламжлан тайлж олсныг чамд нэг нэгээр нурших хэрэггүй биз. Энэ мэтийн нууц бичгийг санаачлан тайлахад бэрхгүй учрыг хэдийн хэлсэн билээ. Дээр дурдсан байдлаар үзвэл уул нууц бичиг нь хамгийн хялбар нууц бичиг болохыг чи батлах биз дээ. Харин эдүүгээ чамд саарь дээр бичсэн зүйл нь юу болохыг орчуулсныг үзүүлбэл ийн буюу. A good glass in the bishop's hostel in the devil's seat forty-one degrees and thirteen minutes north-east and by north main branch seventh limb east side shoot from the left eye of the death's head a bee line from the tree through the shot fifty feet out. Энэ нь «Нэгэн сайн шил

Бишопын костелд чөтгөрийн суудал дээр дөчин нэг хоног ба арван гурван хувь зүүн ба хойт хоёр зүгийн завсар гол гишүүн долоодугаар мөчир зүүн этгээд хохимойн толгойн зүүн нүднээс унага нэгэн шугамаар модноос туссан бөмбөлгийг дайруулан тавин тохой газар цааш» гэсэн үг болно гэхэд үүний учрыг би бас олж үл мэднэ. Урьд адил балар нууцгай байна. Тэр чөтгөрийн суудал, хохимойн толгой Бишопын костел гэх зэргийн мэдэгдэхгүй үгнээс яаж утга олов гэвэл, Легранд үгүүлрүүн: Энэ нь өнгөц үзэхэд нэн ч мэдэхүйеэ бэрхтэй, үүнд би юуны урьд тэрхүү нууц бичгийн үгүүлийг өөрөө бичсэн мэт, таслал тавин хуваав гэв. Тэгээд чи түүнийг цэг тасаллаар ялгасан гэж үү? гэж лавлавал Легранд тийм янзтайгаар үйлдсэн гэв. Чухам хэрхэн учрыг лавлавал, тэрхүү нууц тэмдгийг бичсэн хүн тайлахад улам бэрхтэй болгохын тул үгүүдийг таслалгүйгээр зориуд үргэлжлүүлсэн аж гэж санав. Гэтэл онц ухаантай биш боловч бяцхан зүйлийг төсөөлөх хүн бол түүнийг тайлан чадах нь магад. Түүнийг бичихдээ чухамдаа цэг буюу таслал тавивал зохих газарт тухайлан санаачилж тэмдгүүдийг шахаж тавьсан болно. Түүний уг эх дээр тийнхүү онцоор хавчиж бичсэн нь таван хэсэг газар болохыг үзвэл тодорхой бий. Түүнийг баримтлан би ийнхүү таслал үйлдсэн билээ гэж үзүүлэх нь ийн буюу

A good glass in the bishop's hostel in the devil's seat –
forty-one degrees and thirteen minutes – north-east and by north

– main branch seventh limb east side – shoot from the left eye of the death's head – a bee line from the tree through the shot fifty feet out.

«Нэгэн сайн шил Бишопын костелд чөтгөрийн суудал дээр – дөчин нэгэн хоног ба арван гурван хувь – зүүн хойт, хойт хоёр зүгийн завсар – гол гишүүн долоодугаар мөчирт зүүн этгээд – хохимойн толгойн зүүн нүднээс унага – нэгэн шугамаар модноос туссан бөмбөлгийг дайруулан тавин тохой газар цааш» гэжээ.

Ийнхүү тасалгаа үйлдсэн боловч бас л балар болох учрыг хэлбэл Легранд үгүүлрүүн: Би ч мөн хэдэн өдөр болтол учрыг олохгүй байсан билээ. Түүнээс энэ завсар би тус Сэлливан арлын ойр хавиар Бишопын Костел гэдэг нэр бүхий ямар нэгэн газрыг шамдан ирсэн бөгөөд, юу гэвэл эрт цагт Хостел гэж нэрлэж байсан нь яван явсаар котел гэгдэх болсон учир тийнхүү Бишопын котел гэж ирсэн билээ. Ийнхүү ойр хавиар эрээд юу ч олдохгүй болохоор цааш нилээд хол газар яван нарийн арга хэрэглэж улируулан сурвалжилсан нь гэтэл Бишоп гэдэг үг нь балар эрт цагт тус арлаас умар этгээдэд дөрвөн миль хиртэй газар нэгэн цайзыг эзэлж байсан хүний Бисшоп гэдэг хуучин овгийг хэлсэн аж гэж гэнэт сэтгэгдэв. Түүнээс би ийш тийш хэсүүчлэн нутгийн хөгшин негрүүдээс сурвалжлан явсан нь, эцэст нэгэн туйлын хөгшин эхнэр Бисшопын костил (Энэ нь англи үг. Монголоор цайз

гэсэн үг болно. (орчуулагч)) гэдэг нэгэн газар бий боловч чухамдаа тэр нь урт цайз ч биш харин нэгэн өндөр цохио гэнэ. Үүнд би тэр газрыг зааж өгнө үү? Их шан өгсүгэй гэж гуйсанд тэрхүү эхнэр нэгэн зэрэг цааргалсан боловч даруй зөвшөөрөн намайг дагуулан одов. Түүнээс удсан ч үгүй зүдсэн ч үгүй мөнхүү газрыг олсонд, би хөгшин эхнэрийг хойш буцааж тэрхүү цохиог шинжлэн эхлэв. Энэхүү костел гэгч нь хамаагүй олон хад цохио сэхүйлцэн нухуйлцсан болох бөгөөд тэдний дотор олноос онц өндөр ганцаар зогссон ноён цохио байх нь урлан үйлдсэн мэт нэн ч жигтэй сонирхолтой ажувуу. Би түүний орой дээр авиран гараад хэрхэхийг гайхан авай. Нэгэн зуур ийнхүү эрэгцүүлэн бодмоглож байх үе миний зогсож байгаагаас дор нэгэн метр хирд цохионы зүүн талд гадагшаа бултайсан нэгэн нарийхан ирмэг байхыг гэнэт үзэв. Энэхүү ирмэг цухуйсан нь арван найман ямх, өргөн нь нэгэн тохой бөгөөд яг түүний дээр хадны нэгэн хонгил нүх байх нь бидний эртний өвгөдийн хэрэглэж байсан хөндий налууртай сандалтай нилээд төстэй юм. Түүнээс мөнөөх нууц бичигт үгүүлсэн чөтгөрийн суудал гэгч нь дамжиггүй энэ аж гэж шийдвэрлэсэн бөгөөд нууц бичгийг тайлах замыг олж авав. Бас сайн шил гэсэн нь дуранг хэлжээ гэж сэхээрэв. Юу гэвэл далайн хүн дуранг ердөө шил гэж хэлэлцдэг билээ. Тэгээд энэ явдалд нэгэн дуран хэрэгтэй болох ба үүгээр чухамхүү газрыг олж болохыг мэдсэнээс гадна, мөнхүү нууц

бичигт дөчин нэгэн хоног ба арван гурван хувь зүүн хойт, хойт хоёр зүгийн завсар гэсэн нь дурангаар харвал зохих зүг чигийг заасан болохыг мэдэв. Эдгээр зүйлийг олж мэдсэндээ ихэд бахдан хөөрч, яаран гэртээ харьж нэгэн дуран аваад цохионд гэдрэг буцаж ирэв.

Тэгээд би доош хадны ирмэг рүү үзвэл сууж болмоор нэгэн оновчтой суурь үзэгдэнэ. Энэ нь миний хэдийнээс бодсон зүйлд нийлэлцэв. Зүүн хойт, хойт хоёрын завсар гэж зүг чигийг нэгэнт заасан тул, дөчин нэгэн хоног, арван гурван хувь гэсэн нь чухамдаа ганцхүү тэнгэрийн хаяанаас өндийлгөн үзэхийг хэлсэн болох биз гэж тогтоож мөнхүү чигийг бяцхан луужингаар магадлан дуранг дөчин нэгэн хоногийн өнцөг зүг дээш өргөн ямар ч туслах багаж хэрэгсэл байсангүй учир дээш доош ихэд болгоомжлон хөдөлгөж байтал нэгэн дүгрэг нүх мэт буюу бусдаас өндөрлөсөн нэгэн том модны навчийн завсар мэт юм үзэгдэв. Энэхүү нүхний төвд нэгэн өчүүхэн цагаан юм гялалзахад юу болохыг анхандаа би ер таньж чадсангүй бүлгээ. Даруй дурангийн хол ойрын хэмжээг тааруулж дахин харвал харин нэгэн хохимойн толгой ажуу.

Түүнээс би үүнийг олж мэдээд, би нууц бичиг тэмдэглэлийн оньсогыг тайлав гэж бахдаж урамшсан бөгөөд юу гэвэл гол гишүүн долоодугаар мөчир, зүүн этгээд гэсэн нь ганцхүү тэр модны дээрх хохимойн толгой байгаа газрыг

заасан болох ба хохимойн толгойн зүүн нүдээр унага гэсэн нь нуун далдалсан булшийн сангийн байгаа газрыг тодорхойлохыг үгүүлсэн болох бөгөөд, үүнд нэгэн бөмбөлгийг хохимойн толгойн зүүн нүдээр гэсэн болох ба нэгэн шулуун шугамаар модноос туссан бөмбөлгийг дайруулан тавин тохой газар цааш дат гэсэн нь нэгэн тухайлсан газрыг заасан ба тэрхүү газарт үнэ бүхий эдийг булсан ч биз гэж бодов гэв. Үүнд миний асуусан нь: Эдгээрийг үйлдсэн нь үнэхээр тодорхой бөгөөд мэргэн аж. Мөн ч хялбар бөгөөд ухагдмаар харин чи Бишопын костелоос буцаад хэрхэв гэвэл Легранд үгүүлрүүн: Түүнээс би мөнхүү модыг маш чухал зүйл болгон тэмдэглээд гэртээ буцсан билээ. Чөтгөрийн суудлаас буумагц дүгрэг нүх нь надад үзэгдэхгүй болсон боловч би түүнийг хэзээ хэрхэн олж үзэхийг хүсэлхийлэв. Эдгээр бүхий л явдалд тэр дүгрэг нүх нь ганцхүү хадны ирмэг дээрээс өөр үзэхүйц газаргүй нь нэн ч гайхалтай. Юпитер сүүлийн хэдэн долоо хоногт миний байдлыг ажиг аваад, намайг ер ганцаар явуулахыг үл хүсэх байсан нь дамжиггүй тул Бишопын Костелд одохдоо түүнийг дагуулан явсан билээ. Харин эцсийн өглөө модыг олж үзэхээр ууланд ганцаараа тэнэлээ. Ихэд алжаан эрж түүнийг олж үзээд гэртээ эргэж иртэл миний зарц намайг жанчих гэв. Түүнээс хойш юу болсныг чи надаас дутуугүй мэдэх биш үү? гэв. Бас миний лавласан нь бид нар анх удаа ухахад юу ч гарсангүй нь, Юпитер цохыг

хохимойн толгойн зүүн нүдээр унагавал зохихыг баруун нүдээр унагаснаар чухамхүү газрыг ташаарснаас болсон учир буюу гэвэл, Легранд үгүүлрүүн: үнэхээрийн тийм билээ. Цохыг модны ёроолд унагаахдаа зөвхөн хоёр ямх хагас хирийн газар хазгайлан унагааснаас ташаарагдсан бөгөөд хэрэв булшийн сан нь бөмбөлгийн унасан газар байвал зохих байсан бол бас ч тийм их ташаа гарах газаргүй билээ. Ганцхүү модноос тэрхүү бөмбөлгийг дайруулан шулуун шугам татаж өөр газар малтвал зохих нь хоёр ямх хагасын ташаа нь чухам малтвал зохих газрыг тийнхүү төөрүүлсэн билээ. Эхлэх газраас хоорондын тэмдгийг дайруулан тавин тохой газар шугам татахад хоёр ямх хагасын зөрүү зам нь шугамын үзүүрт даруй хэдэн тохой газрын самуурал болно. Хэрэв булшийн сан нь тэр газар оршино гэж нотод баримталсангүй бол, бидний зүдэрч ажилласан нь талаар хоцрох байсан гэв. Дараагаар би асууруун: Ер нь чи тэрхүү цохыг шижмийн үзүүрт уяж илбэ үзүүлэгч мэт болон эрүүлэн маяглаж явсныг би ч их л гайхсан бөгөөд чамайг магад солиорсон аж хэмээн санаж явсан билээ. Ердөө чи хохимойн толгойн нүдээр нэгэн бөмбөлгийг унагаавал зохихын оронд цохыг унагаасан нь ямар учиртай юм бэ гэвэл, Легранд үгүүлрүүн: Чухамхүү учрыг хэлбэл чи миний эрүүл ухааныг самуурч гэж сэжиглэсэнд би хорсож өөрийн байдлыг

илэрхийлэн чамайг бяцхан эрүүл ухаанаар хуурахыг оролдсон юм.

Тиймийн тул би зориуд цохыг ийш тийш эргүүлж явсан ба түүнийг модноос унагаасан билээ. Чи түүнийг хүнд гэж үзсэн нь надад ийм саналыг төрүүлсэн билээ гэв. Үүнд би асууруун: тийм бол би учры нь оллоо. Ганцхүү лавлах нэгэн зүйл нь булшин дотор байсан хүний яс юу вэ гэвэл Легранд үгүүлрүүн: Энэ нь би ч гээд чамаас тодорхойгоор үл мэдэх нэгэн зүйл юмаа. Энэ тухай таамаглан хэлж болмоор нэг зүйл бий. Гэвч бодвол тэр нь бусчир жигшүүртэй ийм нэгэн үйл болох нь санахуйяа зэвүүн бөгөөд аймшигтай. Кид, хэрэв тэр булшийн санг булсан бол түүнд энэ ажилд туслагч байсан нь дамжиггүй. Хэргээ барсны хойно гэрч этгээдийг сэмээр сөнөөсөн нь лавтай. Нүх малтаж байхдаа тэр өөрт элбэгчийг зээтүүгээр хоёр удаа цохисон байх ч магадгүй, эсвэл арван хоёр удаа цохисон байж ч болно. Хэн түүнийг хэрхэн мэдэх вэ?

Редактор Б.Ринчен

Техн.ред. Г.Долгоржав. Хянагч Н.Санжмятав
Сүхбаатарын нэрэмжит хэвлэх үйлдвэр.
Улаанбаатар. Чойбалсангийн гудамж, 2.

Ebook-г хөрвүүлсэн Виги